

"МОННООС"
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04-р сарын 29 өдөр

Дугаар №01/23

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2023 оны 4-р сарын 29-ны өдрийн 15.00 цагт "UI lounge" рестораны байранд эхлүүлсэн.

ХЭХурлын дарга: Х.Эрдэнэбаяр

Тооллогын комиссын дарга: Л.Пүрэвхүү

Тооллогын комиссын гишүүн: Д.Даваасүрэн

Б.Алтангэрэл нар ажилласан.

Хуралд оролцсон: Монноос ХК-ийн хувьцаа эзэмшигчид:

1. Д.Гиваапил- 69732ш
2. С.Алимаагийн итгэмжлэлээр М.Тунгалаг-14443ш
3. Марал импекс ХХК-ийн итгэмжлэлээр Д.Мөнхбат-69824ш
4. Шандас импекс ХХК-ийн итгэмжлэлээр Л.Нямжав-20556ш
5. А.Дүүрэнбилэгийн итгэмжлэлээр А.Жигүүр-26377ш
6. А.Жигүүр-20176ш
7. Аргай бест ХХК-23ш
8. Б.Ганболд-1ш
9. С.Мягмарсүрэн-506ш
10. С.Пүрэвжав-715ш
11. Г.Алтансүх-954ш

Тооллогын комиссын дарга Л.Пүрэвхүү нь нийтэд гаргасан 350877ш хувьцаанаас 223307ш хувьцаа эзэмшигч буюу 63,64%-ийн саналын эрх бүхий оролцогч оролцсноор хурлыг хүчинтэй гэж мэдээлээд хурлыг эхлүүлсэн.

Хурлын дэгийг ХЭХурлын дарга Х.Эрдэнэбаяр танилцуулж, хуралд оролцогчдын 100%-ийн саналаар батлав.

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Монноос ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх Гүйцэтгэх захирлын тайлан
2. Монноос ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцүүлэх
3. ТУЗ-ийн хараат бус болон энгийн гишүүдийг сонгох
4. Компанийн удирдлагын зардлыг хэлэлцүүлэх

Хурлаар хэлэлцсэн нь:

1. Монноос ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх Гүйцэтгэх захирлын тайланг Х.Эрдэнэбаяр танилцуулав.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Эрхэм хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амгаланг эрэн мэндчилье. Та бүхнээсээ хүлцэл өчье. Нийтэд мэдээлсэн өнөөдөр Plus рестораны тог тасарсан учраас энд ХЭХурлыг шилжүүлж хийж байна. Энэ компаниас хүлцэл хүссэн албан бичгийг танилцуулав. Тайлангаа танилцуулья.

Тайлангийн хугацаанд үйл ажиллагаа нь 2003 оноос бүрэн зогссоноос компанийн тоног төхөөрөмж, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, эд хөрөнгийн бүрэнбайдлыг алдагдуулахгүй хадгалах, газрын эзэмшил эрхийг алдчихгүйн тулд бусдаас их хэмжээний зээл, банкны зээл авч их хэмжээний өрөнд орсон асуудлыг шийдвэрлэх, мөн барилга эд хөрөнгийг улам их механик болон моралын элэгдэлд орж үнэ цэнээ алдах байдлаас сэргийлэх, үнэ цэнээ улам алдаагүй байгаа дээр нь эдийн засгийн эргэлтэнд оруулах асуудлыг Монгол улсын Компаний тухай хууль СЗХ-ны холбогдох журам, компанийн дүрмээр тогтоосон эрх хэмжээний хүрээнд ТУЗ-д оруулан хурал зарлах шийдвэрийг гаргуулсан. Улмаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус 2

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

удаагийн хурлыг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журамд заасны дагуу МХБ-ийн сайтад тавих, өдөр тутмын 2 хэвлэлээр, 2 удаагийн давтамжтайгаар нийтэд мэдээлэх зэргээр зарыг хүргэсний зэргээс МХБ болон СЗХ-нд хурлын мэдэгдлийг хүргүүлсэн. Ингэж хурлын зарыг хууль журамд заасны дагуу нийтэд хүргэж хурлыг хуралдуулснаар 2021 оны 8-р сарын 28-ны өдрийн ХЭХ-аас компанийн үл хөдлөх хөрөнгийг үнэ хүргэн зарж борлуулах шийдвэр гаргасан болно.

СЗХорооноос манай ээлжит бус хурлын шийдвэрийг хянаад, компанийн үл хөдлөх хөрөнгийг бүхэлд нь худалдсанаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх эрсдэл үүсэхээс сэргийлэх арга хэмжээ авахыг зөвлөмж болгосон билээ.

Зөвлөмжийн дагуу ТУЗ нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах гол арга зам нь тэдний хувьцааг шударга үнээр худалдан авах явдал гэж үзэж компанийн хувьцааг нэгтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн юм. Ингээд хувьцаа эзэмшигчдийн хурлыг дахин зарлан хуралдуулж, компанийн нийтэд санал болгон гаргасан 50 ширхэг хувьцааг нэг хувьцаа болгон нэгтгэх, нэгтгэсний дараа үлдсэн бутархай үлдэгдлийг эргүүлэн худалдан авах төслийг хэлэлцэн баталсан билээ. Ингээд хувьцаагаа нэгтгэх замаар хувьцаан бүртгэлд өөрчлөлт гарч буйг бүртгүүлэхээр Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтээ хүргүүлсэн боловч хэсэг хувьцаа эзэмшигчид уг шийдвэрийг эсэргүүцэн СЗХ, татварын байгууллага, шүүх, АТГ-т гомдол гаргасан, гэрээлэгч талд хүртэл шахалт дарамт үзүүлж олон удаагийн албан бичиг өгч, хөрөнгө худалдан борлуулах хэлцэл хийгдэх боломжийг хаасан, мөнгөний эх үүсвэр гаргаж хувьцаа нэгтгэх ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг хааснаас өнөөг хүртэл хувьцаа нэгтгэх асуудал шийдэгдээгүй хэвээр байгаа нь жижиг хувьцаа эзэмшигчдэд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Бид олон хувьцаат компаниуд зах зээлийн шилжилтийн эхний үед үйл ажиллагаа нь зогсож, татан буугдсан, хэлбэрээ өөрчилж хэдхэн хүний өмч болсон асуудлыг бүгдээрээ мэдэх билээ.

Бидний хувьд хэзээ ч хувьцаа эзэмшигчдийн хурлыг тасалдуулаагүй, хурал бүр дээр компанийн санхүүгийн бодит мэдээллийг өгч ирсэн. Үл хөдлөх хөрөнгийн татвар, газрын төлбөр, харуул хамгаалалтын зардал, мөн урсгал зардлууд сар бүр нэмэгдэж хуримтлагдсан өр төлбөрүүд өссөөр байгааг хувьцаа эзэмшигчдэд байнга танилцуулж байсан болно.

Өдий хүртэл компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж хөрөнгийг өөр зориулалтаар мөнгө олох хэрэгслэл болгоогүй, хэлбэрийг өөрчлөөгүй, хөрөнгийг бүрэн хэвийн авч үлдэхийн тулд үл хөдлөх хөрөнгийн татвар, газар эзэмшсний төлбөрийг зээлээр ч болов төлж, өнөөдрийн үнэд хүргэх хэмжээнд авч үлдэж чадсныг цохон тэмдэглэхийг хүсч байна.

Манай ээлжит бус ХЭХ-ын дараагаар компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс хувьцааны үнийг зохиомлоор өсгөж байгаа хууль бус үйлдэл гаргаж байгааг СЗХороонд гомдол гарган шалгуулж байгаа болно.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн гаргасан гомдлоос болж, МонНоос ХК-ийн ХЭХ-ийн шийдвэрүүд цаг хугацаандаа хэрэгжээгүй байсан нь орон нутагт үйл ажиллагааг сэргээх шинэ бизнес эхлүүлэх ажилд саад болж, бизнесийн судалгаанууд төсөл болж хэрэгжээгүй байгаа болно.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн гомдлын дагуу сүүлийн хэдэн сар МонНоосХК-ийн үйл ажиллагаанд Авлигатай тэмцэх газар, Санхүүгийн зохицуулах хороо, ХанУул дүүргийн шүүх, ХанУул дүүргийн татварын алба гэхмэт газруудаас ээлжит бус хяналт шалгалтууд хийгдэж гүйцэтгэх удирдлагыг ажил хийлгэхгүй хэвээр байгаа, өнөөдөр ч шалтгагдаж дуусаагүй байна.

Авлигатай тэмцэх газраас хийгдсэн гэрээ, мөнгө зарлуулалтын анхан шатны бүх баримтад үзлэг шалгалт явуулаад МонНоос ХК-ийн удирдлагыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар халхавчлан хөрөнгө шамшигдуулсан гэх үндэслэл тогтоогүй гэж үзээд хяналтын прокурорын дүгнэлт гарч хэрэгсэхгүй болгосон болно.

Бусад газруудад татварын байгууллага, СЗХ, шүүхэд МонНоос ХК-иас шаардсан бүх бичиг баримтуудыг өгөөд өнөөдрийн байдлаар нийт 9 удаагийн шалгалтад ГЗ, ТУЗ-ийн гишүүд, санхүүгийн ажилтнууд биеэр оролцож мэдүүлэг өгөөд одоо ч шалгалт үргэлжилж байна.

Ингээд компанийн үйл ажиллагаа санхүүгийн байдлыг тайлагнаж.

Нэг. Борлуулалтын орлогын талаар

Манай компани түрээсийн орлогын эх үүсвэрээс орлогоо бүрдүүлж ажилладаг бөгөөд 2021 онд 55.8сая.төг-ийн түрээсийн орлоготой байсан бол өнгөрсөн 2022 оны эхний хагас жилд 4,5 сая.төг-

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ийн түрээсийн орлоготой ажиллаж, 91,9%-аар буурсан. Түрээсийн орлого өмнөх оноос буурсан шалтгаан нь хөрөнгө худалдахтай холбоотойгоор 2022 оны 05-р сард үйлдвэр, конторын барилгыг худалдах тохиролцооны дагуу түрээсийг цуцалж, байрыг чөлөөлж эхэлсэн. Гэвч дээр дурдсан хувьцаа эзэмшигчдийн гомдлоос 2022 оны 6 сар хүртэл гэрээ хийх хугацаа сунжирсан. Харин 2022 оны 7 сард урьдчилсан нөхцөл тохиролцож, гэрээ зурагдаж, эхний урьдчилгаа төлбөр 7 сард орж, улмаар 8 сараас он дуустал хугацаанд 24.4 тэрбум.төг-ийн төлбөр хийгдсэн. Гэхдээ балансад хөрөнгө худалдсан жилээр гэрээний урьдчилсан тохиролцсон үнийн дүнгээр 35.2 тэрбум.төгрөгийг бусад борлуулалт гэдгээр ирээдүйд орох орлогыг тусгаж, татварт тайлагнасан болно.

Ингэснээр жилдээ 30.6 тэрбум төгрөгийн орлоготой ашигтай ажиллалаа.

Хоёр. Зардлын талаар

2022 онд нийт **147,1** сая.төг-ийн зардал гарсан нь өмнөх оноос 1,9 дахин өссөн. Зардлын задаргааг харуулбал:

1. Үндсэн үйл ажиллагааны зардал –147,1 сая.төг

Өмнөх оноос 47,8%-иар өссөн гол шалтгаан нь компанийн хөрөнгийг худалдан борлуулсантай холбоотой байр талбайг чөлөөлөх, мөн гэрээ байгуулахтай холбоотой эрхзүйн туслалцаа авсан зэрэг зардлууд гарсантай холбоотой.

Гурав. Ашгийн талаар

2022 оны тайлан балансын орлогын тайлангаар 30,6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Гэхдээ энэ ашиг нь ирээдүйд орж ирэх орлогыг тайлагнасанаар гарсан ашиг тул, татварын тайлангаар 2,203.1 сая.төг-ийн алдагдалтай гарсан байгаа.

Монноос ХК нь тайлант хугацаанд улсын төсөвт **1,296.3** сая төгрөгийн татвар, шимтгэл төлсөн. Үүнд: ҮХХөрөнгө борлуулсны татварт – 616,9 сая.төг,

Газрын эрх шилжүүлсний Татварт	- 438,9 сая төгрөг
НӨАТатварт	- 46,6 саятөгрөг,
НДШимтгэлд	- 1,75 сая.төгрөг,
Газар ашигласны төлбөрт	- 118,6 саятөгрөг,
ҮХХТатварт	- 58,6 сая төгрөг,
ХАОАТатварт	- 15,0 сая төгрөг тус тус төлсөн.

Дөрөв.Санхүүгийн байдлын талаар

2022 оны тайлан балансыг харахад авлага өмнөх оноос 3 дахин өссөн нь зохих гэрээний дагуу бусдад 11,5 тэрбум.төг-ийн түр санхүүжилт зээл олгосон мөн гэрээний дагуу хөрөнгө худалсанаас орж ирэх төлбөрийг орлогод тусгаж татварт тайлагнаад авлагаар 10.2 тэрбум.төг –ийг бүртгэсэнтэй холбоотой. Өглөгийн хувьд өмнөх оноос 64%-иар буурсан. Энэ нь өмнө хуримтлагдсан бусдад өгөх өглөг, мөн Капитрон банкны зээлийг төлсөнтэй холбоотой

Цаашид хийх зорилтот ажил:

1. Компанийн ноос угаах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг орон нутагт шилжүүлэхээр төлөвлөж, холбогдох судалгааны ажлууд хийгдэж байгаа. Орон нутагт шилжүүлэх ажиллагаа нь хувьцаа эзэмшигчдийн гомдлоос шалтгаалж, гэрээ хийгдэх хугацаа хойшлогдон төлбөр хийгдээгүйгээс нүүлгэн шилжүүлэх ажиллагаа тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.
2. Тиймээс Улаанбаатар хотод эрхэлж болох шинэ бизнесийн судалгааг салбарын инженер, мэргэжилтнүүдийн хүчээр хийлгэж байгаа. Энэхүү судалгаанаас компанид ашигтай шинэ бизнесийг сонгож, шаардлагатай бол компанийн чиглэлийг өөрчилж ажиллах зорилт тавин ажиллаж байна.

2. Монноос ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг ТУЗ-ийн нарийн бичиг Тунгалаг танилцуулав.

Тунгалаг /ТУЗ-ийн нарийн бичиг/ - Тайлангийн хугацаанд Гүйцэтгэх удирдлага нь компанийн бүрэн зогссон үйл ажиллагаанаас компанийн тоног төхөөрөмж, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, эд хөрөнгийн бүрэн байдлыг хадгалах, цаашид маролын элэгдэлд орохоос өмнө эргэлтэд оруулах, үйл ажиллагааг сэргээх асуудлаар ТУЗ-д санал оруулж ТУЗ болон Хувьцаа

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

эзэмшигчдийн хурлаар дэмжүүлж, Компаний тухай хууль СЗХ-ны холбогдох журам, компанийн дүрмээр тогтоосон эрх хэмжээний хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлснээр компанийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн байна. Үүний үр дүнд зөвхөн түрээсийн бага хэмжээний орлогын эх үүсвэрээс орлогоо бүрдүүлж, энэ орлого нь компанийн урсгал зардлыг ч санхүүжүүлж чаддаггүй ажиллаж байсан тус компани 2021 онд 55,8 сая.төг-ийн түрээсийн орлоготой байсан бол өнгөрсөн 2022 оны эхний хагас жилд 4,5 сая. төг-ийн түрээсийн орлоготой ажиллаж, 91,9%-аар буурсан байна. Гол нь хөрөнгө худалдахтай холбоотойгоор 2022 оны 05-р сард үйлдвэр, конторын барилгыг худалдах тохиролцооны дагуу түрээсийг цуцалж, байрыг чөлөөлсөнтэй холбоотой байна. Гэвч дээр дурдсан хувьцаа эзэмшигчдийн гомдлоос 2022 оны 6 сар хүртэл гэрээ хийх хугацаа сунжирсан. Харин 2022 оны 7 сард урьдчилсан нөхцөл тохиролцон гэрээ зурагдаж, эхний урьдчилгаа төлбөр 7 сард орж, улмаар 8 сараас он дуустал хугацаанд 24.4 тэрбум.төг-ийн төлбөр хийгдсэн ч балансад хөрөнгө худалдсан жилээр гэрээний үнийн дүнгээр 35.2 тэрбум.төгрөгийг бусад борлуулалт гэдгээр ирээдүйд орох орлогыг тусгаж, татварт тайлагнасан нь татварын хуульд нийцсэн байна. Ингэснээр жилдээ 30.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, ирээдүйд орж ирэх орлогыг тайлагнасан нь ороогүй орлогын НӨАТ-татвар, ХАОАТ болон үл хөдлөх хөрөнгө борлуулсан болон газрын эрх шилжүүлсний татваруудыг тайлагнаж төлсөн 2,203.1 сая.төг-ийн алдагдалтай гарсан байна. 2022 оны тайлан балансаар авлага өмнөх оноос 3 дахин өссөн нь зохих гэрээний дагуу бусдад 11,5 тэрбум.төг-ийн түр санхүүжилт олгосон, худалсанаас орж ирэх төлбөрийг орлогод тусгаж татварт тайлагнаад, авлагаар 10.2 тэрбум.төг –ийг бүртгэсэнтэй холбоотой байна. ТУЗ-өөс Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан нь компанийн өнөөгийн байдлыг бодитой тусгасан гэж үзээд, Компанийн гүйцэтгэх удирдлагаас 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлыг хангалттай гэж дүгнэж байна. Гүйцэтгэх удирдлагын тайлан болон тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах нь зүйтэй гэж үзлээ.

3. ТУЗ-ын хараат бус болон энгийн гишүүдийг сонгох асуудлыг ТУЗ-ийн нарийн бичиг танилцуулав.

Тунгалаг /ТУЗ-ын нарийн бичиг/ - Та бүхэнд тарааж өгсөн материал дээр ТУЗ-ын гишүүдийн танилцуулга хийгдсэн. ТУЗ-ийн энгийн гишүүнд С.Мөнхжаргал, Билл Холдсворд, Ц.Цэнгэлбаяр, С.Алимаа, Д.Мөнхбат, П.Оюунбаяр, хараат бус гишүүнд Б.Мэдрээ, И.Сэр-Од, Х.Бүрэнтэгш нарыг нэр дэвшүүлж байна. Саналын хуудас дээр нэрс нь байгаа. Энэ жил ТУЗ-ийн энгийн гишүүнээр Д.Мөнхбат, хараат бус гишүүнд Б.Мэдрээ нарын шинээр нэр дэвшүүлж байгаа.

4. Компанийн удирдлагын зардлыг хэлэлцүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичиг танилцуулав.

Тунгалаг /ТУЗ-ын нарийн бичиг/ - ТУЗ-ийн энгийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн 2023 оны цалингийн зардлын төсвийг оруулж байна. ТУЗ-ийн даргын цалин жилд 400,000 төгрөг, гишүүд, нарийн бичгийн цалин 320,000 төгрөг буюу жилд нийт цалингийн зардлын төсвийг 3,280,000 төгрөгөөр батлуулах санал оруулж байна.

5.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-ТУЗ-ийн гишүүд биднийг төлөөлж байгаа учраас ХЭХуралд ирэх ёстой. Гишүүдээс бид юм асуумаар байна.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Өнгөрсөн жилийн хурлын протокол энд байна. Энд ГЗ Эрдэнэбаяр өнгөрсөн жил 35 тэрбум.₮-өөр ямар хөрөнгө, хэдий хэмжээний хөрөнгө зарах гэж байна гэхэд хариулсан хариулт нь байна. Газраа зараад 2,5 га газар үлдэнэ, ийм тохиролцоонд хүрсэн байгаа гэсэн. Одоо бид юу ч үгүй болчихоод энд ирээд сууж байгаа. Энэ дээр та яагаад ингэчихэв, юу болчихов?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Үл хөдлөх хөрөнгөө зарахад хөрөнгө байршиж байгаа газартай нь цуг зарахгүй бол үл хөдлөх хөрөнгө дангаар зарагдахгүй. Үл хөдлөх хөрөнгө газар 2-ыг салгаж болохгүй юм байна гээд хуулийн дагуу цугт нь зарсан. Бидэнд үлдсэн газар гэвэл Нисэхэд байгаа аж ахуйн зориулалттай 8000м газар үлдсэн байгаа.

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Мягмарсүрэн хувьцаа эзэмшигч ингэж асуусан байна. Компанийн 4,6 га газрын хэдэн үлдэж, хэдэн зарагдах вэ гэж асуухад 2,5 га газар үлдэнэ, энэ бол эцсийн тохиролцоонд хүрээгүй байна гэсэн байна.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Эцсийн тохиролцоогоор Монноосны объект байгаа бүх газрын эрх шилжсэн.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Газрын эрх шилжих, газар зарах 2 ижилхэн.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Газрын эрх шилжүүлэх, газар зарах 2 өөр. Газрын эрх шилжихэд газрын хамгийн доод хэмжээгээр үнэлээд татвар төлж байгаа болохоос биш газар үнэлж зарагдаж байгаа юм байхгүй.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Үүнийг протоколд оруулаарай, газрын хууль үзэх юм байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Өнгөрсөн жил ингэж асуусан. Хойд талын контор болон үйлдвэрийн барилгаа цэцэрлэгтэй нь зарах юм байна. Урд талынх агуулахтай хамт үлдэх юм байна. Тусдаа юм байна. Хойд талын газраа 35 тэрбум.₮-өөр зарна гээд ярьсан байгаа. 2021 оны 8-р сард ХЭХурал хийсэн гэж ярьсан.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Наадах чинь буруу тайлбар явагдаж байна. Би тэр үед тэгж хэлснээ санахгүй байна. Протоколоо үзье. Үл хөдлөх хөрөнгийн барилга газрын эрхтэй цуг шилжиж байгаа. Тэгэхээр тодорхой хэмжээний газар авч үлдэнэ гэсэн ойлголт байхгүй.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Тэр үед тал нь үлдэнэ гэж та хэлсэн. Хойд газраа зарна гэсэн.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Тэр үед эцсийн тохиролцоо хийгдээгүй байсан. 2022 оны сүүлээр эцсийн тохиролцоонд хүрсэн.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Таны амнаас гарч байгаа үг хариуцлагатай үг байх ёстой.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Би өөрөө бас хувьцаа эзэмшигч дүүрэнбилэгийг төлөөлж байгаа. Миний асуулт бол түрүү жилд сая хувьцаа эзэмшигчдийн хэлдэг үнэн. Тал газраа зарах гэж байгаа гэсэн. Миний утас дээр бичсэн бичлэг ч байгаа. Гүйцэтгэх захирал таны хувьд ажлаа мэддэггүй болохоор ингээд байдаг юм уу, албаар ингээд байгаа юм уу сүүлдээ ойлгохоо болилоо. Таниас асуухаар хажууд Нямжав орж ирээд хариулаад байх юм. Эсвэл нягтлан руу шидээд байх юм. Та ажлаа мэдэхгүй бол ажлаа хүлээлгэж өгөөд дараагийн гүйцэтгэх захирлыг тавьсан нь дээр. Би түрүү жил төсөл асуусан. Бүтэн жил өнгөрч байна. Төслөө харуулчих, зарахыг чинь эсэргүүцсэн юм байхгүй, ямар ажил хийх гээд байгаа, яах гээд байгааг асуусан. Тэгэхэд та төсөл нь өнөө маргаашгүй бэлэн болно, бид гоё юм хийх гээд байхад яагаад эсэргүүцээд байгаа гээд байсан. Бүтэн жил өнгөрлөө төсөл нь хаана байна. Хэдэн хувьцаа эзэмшигчид гомдол гаргаснаас болоод энэ асуудал нь зогссон юм шиг яриад байна. Төсөл хийж байгаа хүнд гомдол ямар хамаа байна. Та хэд гэрээгээ хийсэн, байраа зарчихсан, төсөл нь хажуугаар нь бэлтгэгдээд явж байх ёстой. Гэтэл хэдэн хувьцаа эзэмшигчдийн гомдол гаргаснаас болоод хамаг ажил зогссон юм шиг, хүүхэд чихэрээр хуурч байгаа юм шиг сонин юм яриад байна. Тэгээд та бүхэн барилга зарсан байна. Зарсан асуудлыг би ойлгосон. 1. Хотын төвд ноосны үйлдвэр байж болохгүй, шинэ төсөл хэрэгжүүлэх гээд байна, 2. Зөндөө өр зээл, банкны өр зээлтэй, үүнийгээ дарахгүй бол хүүний зардал даруулаад байна гээд ярьсан. Сая санхүүгийн тайланг харлаа. Тайланг нэхэж байж, канондож авлаа. Эндээс харахад 11,5 тэрбум.₮-ийг зээл олгосон. Нэр бүхий этгээдэд гэрээний дагуу хөрөнгө оруулалтаас орж ирсэн мөнгийг зээл олгосон байна. Цаана нь нөгөө айгаад байсан зээл, татвар нь үлдсэн байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хэдэн хувиар зээл олгосон бэ? Өгөөж нь ямар байхын?

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Энэ зээлийг ямар компанид олгосон бэ? Хувь хүнд олгосон юм уу? Жилийн хүү нь хэд вэ? Энэ зээл нь ТУЗ-ийн шийдвэрээр олгогдсон байх ёстой. Хэрвээ ТУЗ-ийн шийдвэр гарсан бол ТУЗ-д байгаа хүмүүс чинь бүгд хамаарал бүхий этгээдүүд байгаа. 1. Өндөр дүнтэй хэлцэл болно, 2. Сонирхолын зөрчилтэй хэлцэл болно. ТУЗ-ийн бүх хүмүүс нь сонирхолын зөрчилтэй болох магадлалтай. Сонирхолын зөрчилтэй компанид гаргасан бол мэдмээр байна. Ямар компанид яах гээд зээл олгосон, ямар хугацаагаар олгосон бэ? Уг нь энийг шинэ төслөө хэрэгжүүлэх юм уу, өмнө нь авсан зээлээ төлж барагдуулах ёстой биз дээ. Энэ чинь ямар ч компанид санхүүгийн хувьд асуух асуулт байхгүй юу. Та одоо энэ тухай мэдэх үү, үгүй юу. Би сүүлийн 1 жилд таны энэ мэргэжил, хариуцсан ажилд итгэхээ больж байна. Өөрөө ч хариулж чадахгүй. Ийм асуулт байна. ТУЗ-ийн гишүүд нь дандаа сонирхолын зөрчилтэй гишүүд байна. Болохгүй бол би өөрөө ТУЗ-д ордог ч юм билүү. Та бүхэн эсэргүүцэх байх л даа. Хувьцааны ихэнх 60%-аас дээш

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

эзэмшдэг. Хараат бус гишүүдийг шинээр орж ирж байгаа гэж ойлголоо. Хяналттай баймаар байна. Нэгэнт 30 тэрбум.₮-ийн мөнгөтэй компани болчихлоо. ТУЗ-д ашиг сонирхлын зөрчилтэй гишүүд шийдвэр гаргаад яваад байна. Энд хяналттай явмаар байна. Би өөрийгөө нэр дэвшүүлдэг юмуу гэж бодож байна. ТУЗ-ийн гишүүд нь ХЭХуралдаа ирдэггүй. ТУЗ-ийн дарга болох гэж байгаа Билл Холдсворд хаана байгаа. Адамын ах юмуу, дүү юм уу мэдэхгүй. Ийм хүн тавьчихдаг. ТУЗ-ийн даргынхаа царайг мэдэхгүй, ТУЗ-ийн гишүүдээс ганц Мөнхбат ирсэн байна. Бусад нь хаана байна. Ийм ТУЗ-тэй байгаад 30 тэрбум.₮ хөрөнгөтэй компани цаашид явахгүй ш дээ. Нөгөө төсөл нь явахгүй. Олгосон зээл нь хэзээ авахын? Нөгөө компани нь төлөх ч юмуу, төлөхгүй ч юмуу? Ийм ТУЗ явмааргүй байна. Ийм 3 асуулт байна.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- 1-рт Өнгөрсөн ХЭХурлаар төсөл байгаа, тэр яагаад хэрэгжээгүй вэ гэсэн асуулт байна. Тэгэхээр тэр үед би танилцуулж байсан, жижиг хувьцаа эзэмшигчдийн гомдлоос болоод эцсийн байдлаар гэрээ зурагдаагүй байсан тэр үед. Бид гэрээгээ эцэслэн тохирсон нөхцөл нь 2022 оны сүүлээр эцэслэн тохирсон.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хэдэн сард тохирсон бэ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- 2022 оны 8,9-р сард гэрээг эцэслэсэн.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Гэрээг үзье.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Ийм том дүнтэй гэрээ хийчихээд хугацаагаа мэдэхгүй, түүхэндээ анх удаа ийм гэрээ хийж байгаа биздээ.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Жижиг хувьцаа эзэмшигчдийн гомдлоос болоод бидэнтэй тохиролцож байсан харилцдаг компани гэрээгээ зурж өгөхгүй, итгэл үнэмшил нь болохгүй хугацаа алдсан. Тиймээс орон нутагт ноос угаах үйлдвэр шилжүүлэх төсөл хэрэгжээгүй.

2-рт Хаана зээлсэн бэ? Монноос ХК 2003 оноос хойш үйлдвэр бүрэн зогссон. Жил, сар болгон үл хөдлөх хөрөнгийн татвар, газрын төлбөр, НДШ, банкны зээл байнга өсөөд байсан учраас манай харилцаж ажиллаж байсан Ариг гал ХК нь хүү багатай зээлийн эх үүсвэр олж өгөөд, түүгээр санхүүжилт хийснээр энэ үл хөдлөх хөрөнгөө хадгалж үлдсэн. Тиймээс Ариг гал ХК-д зээл олгосон. Энэ гэрээ нь хийгдсэн байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Гэрээнүүдээ гаргаад ир дээ.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Ариг гал руу зээлсэн гэсэн үг үү. Ашиг сонирхолын зөрчилтэй болчихлоо.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Монноос компанийн үйл ажиллагааг 2003 оноос дэмжсэн тул зээлсэн.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Тэр хамаагүй компанийн тухай хуулиа ярьж байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдсэн байна.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдсэн тул ХЭХурлаар оруулах ёстой байсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдсэн байсныг та нар дур мэдээд хийгээд, компанийн тухай хуулиа зөрчсөн байна.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Ариг гал ХК нь танай компанийн хэдэн хувийн хувьцаа эзэмшдэг вэ?

ТУЗ-ийн нарийн бичиг/- Ариг гал ХК нь хувьцааны 0,1%-ийг эзэмшдэг.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- 0,1% эзэмшдэг бол хяналтын багц эзэмшдэггүй.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Ариг галын эцсийн өмчлөгчийг хайгаад үзэхэд гараад ирнэ.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Марал импекс, Шандас импекс гээд гараад ирнэ.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Тэд нар чинь Ариг галын хувьцаа эзэмшигчид биш. Та нар хуулиа үз. Та нар байгуулагыг ингэж гүжирдэж болохгүй. Эрхзүйтэй бай. Эрхзүйн хүрээнд яв. Монноосны хувьцааг 5%-аас дээш эзэмшдэг бол сонирхлын зөрчилтэй болно.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Эцсийн өмчлөгчийг нь хардаг.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Эцсийн өмчлөгч нь Ариг гал дээр Шандас импекс биш шүү. Та нар хэр хэмжээндээ яриарай.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Шалгуулна.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Шалгуулж болно.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- 2022 оны 8-р сард хэлцэл хийгдсэн гэсэн. Тэр гэрээ хэлцлүүд нь хаана байна. Танилцаадахъя.

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/ - Гэрээ хэлцэл ямар нөхцөлтэй хийснийг үзсээр байна?

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/ - ТУЗ-ийн асуултандаа хариулт авъя. ТУЗ нь яагаад ХЭХуралдаа ирдэггүй юм бэ? Түрүүчийн хурал дээр ганц Мөнхбат ах ирсэн байсан. Ийм ТУЗ-тай баймааргүй байна.

Энхцэцэг /Ня-бо/- Гэрээний хувьд хуульч нар оролцсон баг ажилласан байгаа. Гэрээ нь багийн нарийн бичиг дээр байгаа. Гэрээ эцэслэж 2022 оны 12-р сард нэмэлт өөрчлөлт хийгээд түүнээс хойш урьдчилгаа мөнгөө хийгээд явж байгаа болохоос гэрээг эцэслэн тохироогүй байгаа. Яагаад гэвэл валютын ханшны өөрчлөлтөөс болоод, эргэж үнээ ярьж байгаа учраас эцэслээгүй байгаа. Гэрээний урьдчилсан хэлцлүүд захирал бид 2 дээр ирээгүй байгаа. Би хувийг нь авч үзээд, орж ирсэн мөнгийг нь тулгаад явж байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/ - Төлбөрийн баримт байгаа, тэрийг нь аваад ир.

Энхцэцэг /Ня-бо/- Дансны хуулга дээр байгаа. Бүгдийг Авилгалтай тэмцэх газар, СЗХороонд өгөөд, дахиад Аудитын газарт өгсөн байгаа.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/ - Тэрийг нь СЗХороогоор дамжуулаад та нар авсан биз дээ. СЗХороо, Авилгалтай тэмцэх газар өгсөн учраас тэдгээрийг гомдоод байгаа хувьцаа эзэмшигчдэд хариу өгөөгүй юм уу.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/ - Өнгөрсөн жил ХЭХурлаар танд хүсэлт гаргасан. Одоо хүртэл нэг хуудас гаргаж өгөөгүй байгаа.

Энхцэцэг /Ня-бо/- Гэрээний мөнгө нь компанийн харилцах дансаар орж ирж байгаа. Капитрон банкны өрийг шилжүүлэхийг Шунхлай групптэй гэрээ хийгээд, шууд Шунхлайгаас шилжүүлээд Капитрон банкны зээлээ хаасан байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/ - Тэр чинь Кашмер Холдинг өгсөн мөнгө биздээ. Кашмер Холдингоос мөнгөө авсан юмуу.

Энхцэцэг /Ня-бо/- Аваагүй. Авах авлага гээд балансад тусгасан байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/ - Та нар яагаад Кашмер Холдингийн өмнөөс яагаад төлбөр төлөөд байгаа юм бэ?

Энхцэцэг /Ня-бо/- Кашмер Холдинг аваагүй зээл.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/ - Энэ хурлын протоколд Капитрон банкнаас авсан зээлийг Кашмер Холдингт зээлдүүлсэн гэсэн байгаа. 2021 оны СЗХорооны хяналт шалгалтаар тогтоосон акт байгаа. Ингэж худлаа ярьж болохгүй, та нягтлан хүн байж ингэж болохгүй.

Энхцэцэг /Ня-бо/- Кашмер Холдингт зээлдүүлээгүй, тухайн үед 2019, 2020 онд үйл ажиллагаагаа сэргээх гээд манайх өөрсдөө ноолуур худалдаж авсан. Ноолуурын мөнгийг данснаасаа шилжүүлсэн. Авсан ноолуураа ангилаад, угаах гээд үзсэн, угааж болохгүй. Харин Кашмер Холдингт ноолуураа өгөөд, хоорондын тооцоогоор өглөг авлага үүссэн. Борлуулалт хийе гэхээр 8,9 тэрбум.₮-өөр ноолуур аваад, 1,1 тэрбум.₮-өөр ажиллагааны зардал гарсан. Тухайн үед 2019 онд угаах 2 шугам ажиллуулна гээд ажилчид аваад, 2019, 2020 онд бүтэн ажилласан. Тэгээд уурын зөвшөөрөл өгөгдөхгүй, усны шугам болохгүй, туршилт явж байгаад, бүх ноолуураа Кашмер Холдингт өгсөн. Тэрний хоорондын тооцооны өглөг авлага үүссэн. Кашмер Холдинг төлж явж байгаад, 5,4 тэрбум.₮ болсон.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/ - Ноолуур уу?

Энхцэцэг /Ня-бо/- Манайх өөрсдөө ноолуур бэлтгэсэн. Ноос угаана гээд чиглэлээ өөрчлөөд засвар хийгээд явж байхад 1 ч хувьцаа эзэмшигчид анхаарч үзээгүй. Бүтэн 2 жил үзсэн.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/ - Үйл ажиллагаа яваагүй. Угаасаа энэ чинь социализмын үед маш их зардалтай гэдэг. Би байнга хуралд суудаг мэдэлгүй яахав дээ. Үйлдвэрлэл дээр огт үйл ажиллагаа яваагүй. Яагаад та ингээд худлаа яриад байдаг юм бэ?

Энхцэцэг /Ня-бо/- Явж байсан бичлэг нь байгаа. Ажиллаж байсан хүмүүс нь байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/ - Одоо тжр 11,5тэрбум.₮-ийн зээл олгосон гэдэг нь ямар нөхцөлтэй, ямар компанид олгочихоод байгаа вэ? Монноос бидэнд ямар ашигтай бэ? Хэдий хэмжээний ашиг өгөх вэ?

Энхцэцэг /Ня-бо/- Ариг гал компанид олгосон. Орж ирсэн мөнгөнөөс Ариг галын өр 5,7тэрбум.₮-ийг төлсөн. 11,5 тэрбум.₮-ийг гэрээ хийгээд өгсөн байгаа. Энд үндэслэл нь Ариг гал компани Монноос компанийг авч үлдэхийн тулд өөрөө зээл аваад, бүтэн хүүгийн даагаад, 5%-ийн хүүтэй зээл Монноост олгосон. Түүгээрээ хамтарч ажилладаг болохоороо энэ орж ирж байгаа мөнгийг дэмий

"МОННООС"
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

байхаар сул эх үүсвэрээс 1 жилийн хугацаатай Ариг галд эзэлдүүлье гээд гэрээ хэлцэл хийгээд явж байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Ийм байж болохгүй, жилийн хэдэн хувийн хүүтэй вэ?

Энхцэцэг /Ня-бо/- Жилийн 6%-ийн хүүтэй зээл олгосон.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Ипотекийн зээл олгосон байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Өнгөрсөн онуудад 20 хэдэн хүүтэйгээр Монноосноос Ариг гал өр төлбөрөө нэхэмжилж авсан биз дээ. Кашмер Холдинг аваа биз дээ. Монноосыг өрөнд оруулсан биз дээ. Эсрэгээрээ яагаад буцаагаад өгөхдөө 6% гээд юу яриад байна?

Энхцэцэг /Ня-бо/- 20%-ийн хүүтэй биш. 1,5% байсан, сүүлийн 3 жилд өгсөн санхүүжилт нь тийм байсан. Түүнээс биш эхний хийгдсэн гэрээг анхнаасаа би 2013 оноос хойш авсан. Гэрээ хэлцэл хийгдсэн гол зээл олгосон нь 2013 оноос өмнөх буюу 2003 оноос эхлээд шатлалтай олгосон байгаа. Тэрийгээ нэгбүрчлэн хүүг нь тулгаад тооцоод, тооцоо нийлсэн актаа дор бүрнээ үйлдээд явж байсан. 2016, 2017 оны эцсээр. Харин сүүлийн 3 жилийн буюу 2021,2022,2023 оны хүүг зогсоосон байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- 2009-2013 оны хооронд Шандас импекс, Ариг гал гэсэн 2 компаниас зээл авсан байсан. Тэр үед та ажиллаж байсан уу? Та юу хийж байсан бэ? Тэр их мөнгөөр Монноос ямар үйлдвэр эрхэлж байсан бэ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Хуримтлагдсан өр төлбөрөө төлж байсан. Сар болгон үл хөдлөх, татвар гэх мэт зардлуудыг төлж байсан. Өмнө нь хуримтлагдсан өр төлбөр байсан.

Энхцэцэг /Ня-бо/- Өмнөх хуримтлагдсан өр төлбөр байсан. 2009 оныг сайн мэдэхгүй байна. Би 2013 оны 2,3-р сараас эхлэн ажилласан.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Энхцэцэг ня-богоос асууя. Та ажлаа хэдэн жил хийж байгаа вэ? Таны мөнгөн гүйлгээний тайлан шал худлаа, буруу байна. Доор үл хөдлөх хөрөнгө зарсан орлогоос оруулах ёстой тоог дээр үндсэн үйл ажиллагааны орлого болгоод оруулчихсан.Зээлийн төлбөр төлснийг тавьсан байна. Хүүгийн төлбөрийг хаана ч тавьсан байна. Миний асуух гээд байгаа зүйл бол бусад мөнгөн орлого нь 23,7 тэрбум нь гэрээ хийгээд орж ирсэн мөнгө юм шиг байна. Бусад мөнгөн зарлага нь зээлсэн мөнгөө тавьсан юм шиг байна. Энэ 2-ын хооронд 6 тэрбум.₮-ийн бусад зардал нь хаачихсан юм. Би мөнгөн гүйлгээг тань ойлгохгүй байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Та баримтуудаа аваад ирээч. Худалдах худалдан авах гэрээний баримтуудыг аваад ирээч.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Гэрээ хэлцлүүд, өмнөх гэрээг ч гэсэн хармаар байна.

Энхцэцэг /Ня-бо/- Надад худалдах, худалдан авах гэрээ байхгүй. Би нягтланг давхар хийдэг болохоос биш гэрээ хэлцлүүд ирдэггүй.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Энэ 6 тэрбум.₮ нь татвар юмуу гэхээр тусад гаргаад тавьчихсан байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Гэрээтэйгээ танилцмаар байна. Хэзээ хийгдсэн гэрээ вэ? Санхүүгийн зохицуулах хороо 2022 оны хэдэн сард худалдан борлуулах зөвшөөрөл олгосон бэ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- 2022 оны 2-р сард олгосон.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- 2-р сард зөвшөөрөл олгоод хэдэн сард гэрээгээ хийсэн бэ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Гэрээг 2022 оны 7-р сард хийсэн. Гэрээний нөхцөл тохиролцож чадахгүй байгаад байсан. Сая Энхцэцэг нягтлан хэллээ. 12-р сард хүртэл гэрээний нэмэлтүүд орж ирж байсан. Энэ гэрээ нь энэ болохгүй байна, тэр болохгүй байна гээд өөрчлөгдөж байсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Шунхлайгаас нэмэлт орж ирсэн үү.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Хуулийн багууд ажиллаж байсан. Тэд нар хуулийн дагуу ингэх ёстой гэж өөрчлөгдөж байсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Жижиг хувьцаа эзэмшигчид бидний зүгээс маш их гомдолтой байгаа. Яагаад гэвэл зах зээлийн үнийн дагуу зараагүй.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Наад гомдлын дагуу АТГ, татвар, СЗХороо бүгд шалгагдаад явж байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Та өвчтэй гээд очихгүй байгаа гэсэн.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Та зугтаагаад яваад байгаа. Энхцэцэг нягтлан би бараг байхгүй болсон, ажилладаггүй гэж хэлсэн гэсэн. Та өвчин зовлон гэсэн. Над руу нягтлан нь ярьсан. Одоо ч гэсэн залгаад асуусан ч болно. Тэгээд цагдаагаар эрэн сурвалжлаад явж байгаа гэсэн.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Хэнийг намайг уу?

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Тийм

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- За болиорой.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Тийм. Албадан авчирч бичиг баримтуудыг нь гаргуулах гэж байгаа гэсэн.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- АТГ, Татвар, СЗХороонд нягтлан баримтаа өгөөрэй гээд үүрэг өгсөн байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Нягтлан өгөөгүй биз дээ?

Энхцэцэг /Ня-бо/-Өгсөн.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Татварт өгөөгүй юм уу?

Энхцэцэг /Ня-бо/-Өгсөн. 3-р сард СЗХороонд өгөөд, манайх давхар давхар

Эхлээд АТГазарт оны өмнө өгсөн. Очиж уулзаад явж байтал манай ар гэрт асуудал гарсан. Би давхар ажилладаг, ганцхан Монноосны дээр ажилладаггүй. Тэгээд болохгүй болохоор нь би 2 сарын чөлөө аваад ирсэн. Яг баланс тайлан гаргах үеэр байгаагүй. Хүүхэд өвдсөн.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Цаг заваа ажилдаа гаргаж чаддаггүй хүмүүстэй баймааргүй байна. Одоо мөнгөтэй болчихлоо. Ажлаа хийх гэж байгаа бол чадалтай чадвартай хүмүүс орж ирээд төсөл хэрэгжүүлнэ гэхээс биш шалтаг тоочсон хүмүүс байна. Та хэдэд төсөл нь алга, ажил нь яаж явах нь бүү мэд.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Гол нь хувьцаа эзэмшигчдийг төлөөлөөд, том хэмжээний хэлцэл хийчихээд зах зээлийн үнээс маш бага үнээр хийсэн байгаа. Хан-уулын газрын зах зээлийн үнийг судлаад үзэхээр.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Нийт 4,5 га газар байгаа. Үл хөдлөхтэй 35 тэрбум.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Гэтэл өчигдөр Ариг гал хэлж байсан. Бид Оргилд газраа зарсан. 1,5 га газраа 5 сая доллараар зарсан гэсэн. Та бодоод үздээ. 4,5 га газар 10 сая доллараар зарсан байна. Тийм бага үнээр зарж болохгүй.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Үнийг яаж тэгж тогтоосон юм бэ? Ямар үнэлгээгээр хийсэн бэ?

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Том байх тусмаа үнэтэй байгаа байхгүй юу. Дээрээ бас үл хөдлөх хөрөнгөтэй шдээ.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Хан-Уул дүүрэгт газар авья гэж харалдаа. 500м газар 1 тэрбум байгаа. Хамгийн багадаа шдээ.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Бид нар тэнэг хүмүүс биш. Судлаад үзсэн. Үл хөдлөх хөрөнгө зуучуудтай хамтраад ажиллаж байна. Ремакстай уулзаад явж байна. Тэр хавийн газруудыг судлаад явж байна.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Ариг гал өөрөө тэгж зарсан байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- 2019 онд Ариг гал хоосон газрыг сайн зарсан байгаа байхгүй юу. Монноос том хоолтой газар шдээ. Худалч хүнд Нарны хорооллыг босгох хэмжээний том газар.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Одоо тийм газрыг эндээс хайгаад олохгүй.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Нарны хорооллын газрыг 2007 онд 11 сая доллараар авч байсан гэсэн.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Ковидын үед Монноосыг өндөр үнээр зарах гээд зөндөө судалгаа хийж байсан.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Тэр судалгаа чинь байсан юмуу. Бид нар харья л даа.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Хөрөнгө зарж борлуулах комисс хүртэл байгуулсан.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Газраа зарсан гэрээгээ хүртэл бидэнд харуулахгүй байна шдээ. Тэр хэлцлийг чинь үзмээр байна. Юу болсон мэдэгдэхгүй тоо тавьчихаад, галзуу хүний өдрийн тэмдэглэл шиг байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Бид нэгнийгээ муухайгаар хэлэх, маргалдах огт шаардлагагүй. Гол нь баримттай юмаа хараад танилцмаар байна. Бид нар таныг загнаад, муулаад байгаа юм огт биш. Зүгээр хууль эрхзүйн хүрээнд шаардаад байгаа.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Энийг хэдээр зарж борлуулсныг мэднэ шдээ. Тодорхой хэмжээний цаг хугацааны асуудал байгаа. Хаашдаа мэднэ.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Биднээс нуугаад хол явахгүй.

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Мөнгөн хөрөнгийн зарлагын дүн дээр зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн гэсэн байна. Энэ юу вэ? Бонд гаргасан юм уу? Хувьцаа гаргасан юмуу?

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Зээлийн эх үүсвэрээ бичсэн юм шиг байна. Зарлага гээд 17тэрбум.₮ юуны зарлага гарсан бэ?

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Ийм том дүнтэй бусад зардал юу гарсан бэ?

Энхцэцэг /Ня-бо/- Энэ бол банкны зээлтэй байсан учраас 5,4 тэрбум.₮-ийн Капитрон банкны зээлийн үлдэгдэлтэй байсан тэрийгээр зээлээ төлсөн. Хүү нь 145,5сая байсан ба нийт 5,6тэрбум.₮-ийг төлсөн.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- 5,4 тэрбум.₮ ямар учиртай аваад төлсөн зээл бэ?

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Кашмер Холдингт зээлдүүлсэн зээл. Тэрийгээ төлсөн.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- 17,3 тэрбум.₮ ямар учиртай юм бэ?

Энхцэцэг /Ня-бо/- 17,3тэрбум.₮ бол хоорондын тооцоогоор хийсэн мөнгийг энд бичсэн. Ариг гал руу орсон мөнгө. Энэ нь Ариг галд 5,7 тэрбум.₮-ийн өртэй байсан, тэрийгээ төлсөн. Өр авлага дээр бичсэн байгаа. Авлага дээр 11,5тэрбум.₮ үлдсэн. Одоо бол өр төлбөрийг харахад 2,7 тэрбум.₮ үлдсэн. Одоо Шандас импексийн 2,3тэрбум.₮-ийн өртэй, бусад нь жижиг харилцагчдийн өр байгаа. Ариг галын 5,7тэрбум.₮-ийг өртэй, баталгаажилт хийсэн, акт тооцоо нь байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Эрдэнэбаяр захирлаас дахиад юм асууя. 4,6га газрыг АПУ, Шунхлай, Шунхлай холдинг гэсэн 3 газарт яг хэдэн төгрөгөөр зарсан бэ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- АПУ, Шунхлай 2т зарсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Тэр 2т хэд хэдэн төгрөгөөр зарсан бэ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Нийт 35,2тэрбум.₮-өөр зарсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- АПУ-д ямар газраа хэдээр зарав, Шунхлайд бас ясар газраа хэдээр зарав?

Энхцэцэг /Ня-бо/- Би тэрийг нарийн сайн мэдэхгүй байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Та нягтлан нь биздээ, та очиж суусан биздээ.

Энхцэцэг /Ня-бо/- Гэрээ хэлцлийг хийхэд би оролцоогүй.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Комисс гараад тохиролцоо хийгээд, гэрээ хэлцлээ хийсэн. Бидэнд хийгдсэн гэрээ ирсэн. Би сүүлийн 4,5 жил сахарын өвчнөөс болоод зовж байгаа, ихэвчлэн гэрээсээ ажлаа явуулдаг. Мэргэжлийн хүмүүс комисс болоод ажиллаж байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Комисс гээд байгаа ямар хүмүүс байгаа вэ? Тэрийг харъя.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Эрдэнэбаяр захирлаа, та энэ хурлаар өөрийгөө дахиад 1 жил гүйцэтгэх захирлаар тавих гэж байгаа юу?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Үгүй. Би чөлөөлөгдөх хүсэлтээ ТУЗ-д өгсөн байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Одоо юу ч үгүй болгочихоод байна.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Одоо бид нар энэ компанид найдаж суух юмуу, юу ч үгүй компанид сууж байна. Одоо нисэхэд 1 газар байна, гацууртад 1 газар байна. Тэрэнд найдаж суух уу. Цаашдын үйл ажиллагаа гэж байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Талыг нь зарна гэхихээд бүгдийг зараад дуусгачихсан. Ингэж хууран мэхэлж болохгүй шдээ.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Хойд талын газраа 35 тэрбум.₮-өөр зараад, цаана нь тал 1,3 га үлдэнээ гэсэн.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Та нарын гомдол гаргаад, түүний дагуу шалгагдаад явж байгаа. Сүүлийн 6 сар шалгагдаад явж байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Та яаж ёсзүйн хувьд, ГЗ-ын хувьд болохгүй шдээ. Урьд нь ярьсан юмаа үгүйсгээд байх юм. Гэрээ үзье гэхээр гэрээ үзүүлэхгүй, журналын бүртгэлийг харья гэхээр байхгүй.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Тэгэхээр чинь энэ хурлын үр гэж байхгүй байна.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Хэлцлийг баталсан ТУЗ-ийн гишүүдээс энэ хүн Мөнхбат сууж байна.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Та ТУЗ-ийн хурал дээр юу гэж яригдаад, баталсныг ярьж болно шдээ.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Тунгалаг /ТУЗ-ийн нарийн бичиг/- Мөнхбат энэ жилээс ТУЗ-д орж ирж байгаа. Түрүү жилийн ТУЗ-д байгаагүй. Энэ жил Мөнхбат ТУЗ-ийн энгийн гишүүнээр, Б.Мэдрээ хараат бус гишүүнээр нэр дэвшиж байгаа.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Сая 11,5тэрбум.₮-ийн зээл авдаг компанийн хүн байна. Ингээд сонирхолын зөрчил гарч ирж байна.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Байнга ингээд 2 талдаа байгаад баймааргүй байна. Бүгдээрээ нэг талдаа гармаар байна. Хаашдаа бид нар мэдэх юм дээр ингэх хэрэггүй.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Одоо тэгээд ТУЗ-ийн хурал дээр 11,5тэрбум.₮-ийг төлүүлбэ гэхэд Мөнхбат бол үгүй байлгаж бай гэнэ шдээ. Наадах чинь манай компани хэрэглэсэн гэнэ.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Мөнхбат та ТУЗ-ийн энгийн гишүүнд сонгогдох гэж байгаа юм байна. Цаашдаа Монноос компанид юу хийе гэж бодож байна.

Марал импекс/Хувьцаа эзэмшигч/- ХЭХурлаар сонгогдвол орон нутагт эхлэх угаах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор орж ирж байгаа. Хотод ноос угаах, арьс ширний үйлдвэрийг ажиллахгүй байгаа. Иймээс орон нутагт ноос угаахыг сая Энхцэцэг хэлсэн 1 шугамыг бүрэн засварлаад ажиллуулж эхэлсэн. Та нар түүн дээр оролцоогүй, ирж үзээгүй байх. 1 шугам бүрэн болоод бэлэн байгаа. Одоо үүнийг орон нутагт хөгжүүлэх тал дээр ажиллана. Миний эхний бодол ийм байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Таны өмнө төсөв төлөвлөгөө байна уу?

Марал импекс /Хувьцаа эзэмшигч/- Түүнийг тухайн үедээ ТУЗ дээр төсөв төлөвлөгөөгөө танилцуулна.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Зарахаас өмнө орон нутагт юм хийнэ гэсэн төсөл хийсэн. Одоо хүртэл гараагүй, биежээгүй байна. Та нарын хийсэн юмнууд нэг ч өгөхгүй байна. Хувьцаа нэгтгэх хөтөлбөр үзье гэсэн байхгүй. Хороонд ч өгөөгүй.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Хувьцаа нэгтгэх төслийг Хороонд өгсөн байгаа. Хороо манай төслийг үзэж хараад зөвлөмж өгсөн.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Өгөөгүй гээд хорооныхон шүүх дээр материал нь байгаа. Эндээс болж шүүхэдсэн шүү.

Тунгалаг /ТУЗ-ын нарийн бичиг/- Хувьцаа нэгтгэх төсөл, материалыг Хороонд өгсөн.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хөрөнгө зарах, хувьцаа нэгтгэх төсөл дээр хорооноос зөвшөөрөл өгөөгүй биз дээ.

Тунгалаг /ТУЗ-ын нарийн бичиг/- Хувьцаа нэгтгэх асуудал дээр Хорооноос зөвшөөрөл ирээгүй. Яагаад гэвэл жижиг хувьцаа эзэмшигчдийн гомдол ирсэн учраас шууд шийдэхгүй гэсэн. Шалгаж үзэж байгаад хариу өгнө гэсэн. Хөрөнгө худалдан борлуулах дээр зөвшөөрөл ирсэн.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хорооны тогтоол шийдвэр үү, зөвхөн 1 даргын үсгээр шийдэгдсэн үү.

Тунгалаг /ТУЗ-ын нарийн бичиг/- Мэдэхгүй. Хорооноос зөвшөөрсөн албан бичиг ирсэн.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Мөнхбат даргаа хөдөө орон нутагт тэр үйлдвэрээ битгий хийж үзээрэй.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Та нарыг хийхээс өмнө аль хэдийн мини үйлдвэрүүд зөндөө очсон байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Очоод, хийгээд, тэр нь ашиггүй болоод, Архангайд зарна гээд тавьсан зар байна.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Говь-Алтайд усгүй газар яаж угаах үйлдвэр ажиллуулах гэж байгаан? Юугаар угаахын?

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Орон нутгаас зөвшөөрлөө автлаа холоо .

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Тэрийг битгий хийж үзээрэй. Нохойн замаар ороод, мөнгө маань дуусна шүү. Улаанбаатар хотод 2002 оноос хойш энэ их зээл авчихаад, одоо хүртэл нэг ч үйл ажиллагаа явуулж чадаагүй. Дахиад үйл ажиллагаа явуулна гэхэд итгэхгүй байна.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- 4,6 га газрыг энэ үнэлгээгээр зарсан гэдэгт итгэхгүй байна, бид хардах эрхтэй. 1м2 газрыг хэдээр зарсан гэж бодож байна. Өнөөдөр хэдтэй байгаа вэ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Одоо надад судалгааны материал байхгүй байна.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Ариг гал тэгэхэд 1,1 га гөзрыг 5сая доллараар 2019 онд зарсан байна.

"МОННООС"

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Энхцэцэг /Ня-бо/- 2019 онд биш шүү. 2020 онд ТУЗ-ийн шийдвэр нь гараад, 2021 онд гэрээ нь эцэслэн зурагдсан гэж хэлсэн.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Гэтэл ТУЗ-д Шандас импексийн төлөөлөл байгаа. Тэгсэн хэрнээ ийм хэлцэл хийж байх уу? Зах зээлийн үнэлгээгээ хараад, жишиг ханшаа Үнэгүй сайтаар ороод 1 га газар Хан-Уулд хэдтэй байна уу. Мэдэж байгаа ш дээ.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Судалж байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Би зүгээр халхавчилсан гэрээ хийж байгаа гэж бодож байна. Сая Нямжав газрыг үнэгүй шилжүүлсэн гэж хэлсэн.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Газрын эрхийн үнэ гэж байгаа. Газрын эрхээр заавал төлбөр төлж, тавар төлдөг Газрын тухай хуулиар.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Бүсчилсэн ханш тогтоосон байдаг. Хүн болгон тэгж хийж байгаа.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Тэрнээс биш үнэгүй шилжүүлсэн гэж хэлээгүй. Эрх шилжүүлэхэд заавал төлбөр төлж татвар төлдөг.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Энийг чинь бид заргалдаад явахаас өөр арга байхгүй. Гомдол мэдүүлээд. Татвараас нуун зайлсан болж байгаа.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Шалгуулаад явж байгаа.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Одоо Адам байхгүй байгаа юм байна. Хамгийн том хувьцаа эзэмшигчид Мөнхбат, Нямжав төлөөлж юм байна. Та хэд ТУЗ-ийг батлах гээд байна уу? Би бол ТУЗ дээр дахиж энэ хүмүүсийг баталмааргүй байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- ТУЗ-ийг хэр сайн ажилласан гэж та хэд үзэж байна. 2022 онд Компанийн төлөө сайн ажиллаж чадав уу?

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Одоо ТУЗ-ийн гишүүд энд суугаад, бид ТУЗ-ийн гишүүдээс юу болчихоо гээд асуугаад сууж байх байсан. ТУЗ-ийн гишүүд байхгүй бол ТУЗ-ийг төлөөлж байгаа Гүйцэтгэх захирал бүх юмаа мэдэх ёстой.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Компанийн оффис ч байхгүй, царай алдаад энд сууж байгаа бидээ. Мөнгөөрөө 6%-ийн зээл олгочихсон.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Зээл нь инфляция ч барихгүй байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Хараат бус гишүүд, болон гишүүдэд нэр дэвшиж хүмүүс энд сууж байгаа хүмүүс байгаа юу? ТУЗ-ийн гишүүд хариуцлага хүлээх эрх бүхий этгээд шүү дээ. Хувьцаа эзэмшигчдийн тэнцвэртэй эрх ашгийн төлөө ажиллах ёстой. Нөгөө талдаа сонирхолын зөрчил үүсээд яваад байна. Танд гэж зөвлөхөд Мөнхбат та нэрээ татсан дээр шүү. Та эндээс зүгээр өнгөрөхгүй шүү. Тэгээд юм асуухаар хэлэхгүй, гэрээ байна уу гэхээр байхгүй, ноос угаах төсөл нь байна уу гэхээр одоо хийнэ гээд сууж байдаг.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Хурлын материал дээр хамаг ажил нь бид хэдээс болоод явахгүй байна гээд бид нар луу хамаг буруугаа чихээд байдаг, олон нийтэд зарлаад байдаг.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Таны өгсөн энэ тайлан дээр гомдол гаргана. Худлаа хэлснийг чинь нотолно.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Эрх нь та нарт байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Эрх нь байгаа, нотолно. Ингэж хурал хийгээд, ийм засаглалтай компани авч яваад болохгүй.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Бид нарыг хохироосон ч гэсэн, цаана нь улсыг татвараар хохироосон гэж байгаа мэдэж байгаа биз.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- 1800 гаруй хувьцаа эзэмшигчидтэй. Та нар Хороо мороо, хонгил монгилоор яваад болж байна биз, дуусахгүй шүү.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Та нар Хороо, АТГ руу яваад аргалж болно.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Гишүүн Мөнхжаргал нь Ариг галын ТУЗ-ын дарга нь юм байна. Манай ТУЗ дээр орж ирээд зээлээ гаргачихсан. Өмнө ТУЗ-ийн дарга нь Мөнхжаргал байлуу.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Үгүй. ТУЗ-ийн гишүүн.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Гишүүн нь ороод өөрийн компани руу 11,5тэрбум.₮-ийг гаргасан байна. Энд ашиг сонирхол гарч байна. Цэнгэлбаяр гишүүн байсан тээ. Цэнгэлбаяр нь Ариг галын Ерөнхий ня-бо. Бөөн Ариг галын хүмүүс байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Энэ компанид ирээдүй байна уу? Одоо яахын?

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Эсвэл энэ компаниа татан буулгая хэдүүлээ. Таны хувьд Говь-Алтайн усгүй газар очоод, ноос угаах үйлдвэр бариад ашиг олно гэж хувь хүний хувьд итгэл байна уу?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Говь-Алтай, Өвөрхангай аймагт төлөвлөлттэй судалгаа явагдаж байсан болохоос тэнд шууд байгуулчихна гэж хэлээгүй.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Тийм юм хийнэ гээд энийгээ зарж байгаа шдээ. Зарах нөхцлүүдийн нэг. Энд ноос угаалгахгүй байна гээд үйлдвэрээ татан буулгаад зарья, дахиж үргэлжүүлж хийх арга алга гээд зарж байгаа. Бид нар халааснаасаа мөнгө гаргаж, хувьцаа авч байгаа шдээ. Өөрсдийнхөө хөдөлмөрлөж, хөлс хүчээ шингээж олсон мөнгөөрөө худалдаж авч байгаа, энэ компанийг судалж үзээд авсан байгаа. Тэгэхэд Энхцэцэг гэдэг хүн мэдэж байгаа байх. 2019 онд танай тайлан дээр тийм хэмжээний өр байсан уу? Хэдээс хэдэн он хүртэл тайлангаа өгөөгүй вэ? Хэдэн онд ямар хэмжээний өр байсан. 2009-2012 онд тийм өр байсан юмуу? Тайлан дээр тусгагдаагүй. Одоо энэ компаниа, зарсан юмаа ч гэсэн үнэнээ хэлмээр байна. Үнэт цаасны хадгаламжийн төв дээр та нарын барьцаалсан АПУ-гийн хувьцаа байгаа биздээ. Тэрийг яагаад ярихгүй байгаан?

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Та нар ярихгүй байгаа ч гэсэн бид тодорхой хэмжээний мэдээлэл авсан байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Яагаад нуугаад байгаан. Хэлэл дээ.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- АПУ-гийн 1% хувьцаа барьцаанд байгаа. Тэр хэлцэлийг үзмээр байна.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Тэрийг Эрдэнэбаяр захирлаа мэдэж байга юу?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Мэдэж байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Захирал нэртэй боловч мэдэл нь энэ хүнд юм шиг байна.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Өөрийн компанийн хэмжээнд хийсэн гэрээгээ мэдэхээс өөрийг мэдэхгүй.

Энхцэцэг /Ня-бо/- Мэдэж байгаа. Мөнгөө төлөөд, хугацаа дуусахаар чөлөөлж өгнө.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- 11,5 тэрбум:₮-ний зээл барьцаа байгаа юу? Барьцаагүй 6%-ийн зээл юм биш биздээ.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Барьцаагүй зээл олгоод, биднийг доромжилж байгаа гэж үзэж байна. Юм асуухаар мэдэхгүй гээд, мэдэж байгаа шдээ.

Энхцэцэг /Ня-бо/- Барьцаагүй. Та нарыг доромжилсон юм байхгүй. Та нар 20 жилийн хугацаанд энэ компанийн эд хөрөнгийг авч үлдэхийн тулд Ариг гал ганцхан дэмжлэг үзүүлээд ажилласан. Тэгэхээр Ариг галаас хүсэлт тавьсаны дагуу Ариг галтай бид нар эргээд хамтран ажиллах ажиллагаа байна биздээ.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Бизнес биздээ.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Найран дундаа байж болохгүй.

Энхцэцэг /Ня-бо/- Найран дундаа биш. 2 компанийн хоорондоо санамж бичиг үйлдээд, протокол үйлдээд явж байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Компани гэдэг чинь ашгийн төлөө байдаг болохоос сайн дурын байхгүй.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Нарийн хүүгээ тохирсон гэрээ хэлцэл нь байгаа байх.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Компани үл хөдлөх хөрөнгөө зарчихаад байна. Та тэрэн дээр юу гэж үзэж байна. 35,2 тэрбум:₮-өөр зарсан байна.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Ноосны үйлдвэрийг ноолуурын үйлдвэр нь дэмжсэн байна. Энд сүйд болоод, аваад идсэн юм шиг болоод байх юу байгаан. Үндэсний нэг үйлдвэр. Яг нарийндаа ярьвал нэг толгойтой 2 үйлдвэр байсан. Нэгдлийн харьяанд. Тийм учраас бусад компаниуд дампуураад, өөр төрөл руу шилжиж байхад ний нуугүй ярихад Ээрмэл компани ноосыг ашиглаад ганцаар үлдсэн. Хувьцааг нь тодорхой хэмжээгээр авч байгаад сүүлд нь бие даагаад гарахад буцаагаад өөрсдөд нь шилжүүлж байсан асуудал байгаа. Тэгээд өнөөдрийг хүртэл 2 зэргэлдээ үйлдвэр явчихаад үндэсний үйлдвэрээ хамгаалаад, өр ширийг нь дараад, өөртөө байхгүй боломжоо хүртэл эднийд дайчлаад 2-3,5% хүүтэй зээл олдохгүй байхад Банк бус байгууллагаас зээл авчихаад, Монноос компанид 1%-аар зээлдүүлээд зөрүүг нь өөрсдөө дааж байсан Ариг гал компани шүү. Би бодитой зүйлийг ярьж байна. Яагаад үүний хариуд ноолуур

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

бэлтгэх үед нь санхүүжилт өгч болохгүй байгаан. Яагаад үндэсний ноолуурын үйлдвэрийг дэмжихэд болохгүй байгаан. Буцаагаад зээлээ авна шдээ. Одоо сул чөлөөтэй, янз бүрийн төсөл хэрэгжиж эхлээгүй үед тэр мөнгийг зүгээр байлгахаар тодорхой хэмжээний хүүтэй санхүүжилтээр ноолуурын үйлдвэрээ дэмжиж болдоггүй юм. Энэ чинь хулгай биш биздээ.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Гол нь энэ чинь сонирхолын зөрчилтэй хэлцэл болсон байна. Энийгээ яагаад Хөрөнгийн бирж дээр тавьсангүй вэ? ХЭХурлаар хэлэлцүүлэх асуудал байсан байна шүүдээ. Их хэмжээний сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх гээд байна, ХЭХурлаар оруулна, тэгж байж шийдэх асуудал байна, Эрдэнэбаяр захирлаа та бол 11,5тэрбум.₮-ийг дэмжихгүй гээд та хэлэх ёстой байхгүй. Яагаад гэвэл та хувьцаа эзэмшигчдийг төлөөлөөд сууж байгаа хүн шүүдээ.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Дээр нь Кашмер Холдингоос дахиад 5,7 тэрбум.₮. Тэрийг нь Кашмер Холдингийн өмнөөс Капитрон банканд төлөөд дууссан байгаа.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Тэр чинь Монноос компанийн авсан зээл.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- 5 тэрбум.₮-ийн зээл жилийн хэдэн хувийн хүү төлдөг вэ?

Энхцэцэг /Ня-бо/- 5,6 тэрбум.₮ зээл бол Капитрон банкны сарын 1,6%-ийн хүүтэй зээл байсан. Шунхлайгаас мөнгө аваад төлөөд дууссан.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Одоо үлдсэн ямар зээл байгаан? Өглөг дээр байгаа юу вэ?

Энхцэцэг /Ня-бо/- Одоо банкны зээл байхгүй. Өглөг дээр 2,7 тэрбум.₮-ийн өглөг байгаа. Шандас импексийн 2,3тэрбум.₮, бусад холбоотой компанийн өглөг үлдсэн байгаа. Шандас импексийн зээл тухайн үеийн тохирсон хүүгээрээ явж байгаа.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Хүү нь хэд вэ?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Сарын 0,5%-ийн хүүтэй.

Энхцэцэг /Ня-бо/- Сарын 0,5%-ийн хүүтэй, тооцоо нийлсэн акт үйлдсэн байгаа.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Харъя

Энхцэцэг /Ня-бо/- Бүх баримтууд Аудит гээд дамжаад явж байгаа учраас надад анхан шатны баримт байхгүй байгаа. СЗХорооноос аваад Аудитын компанид 4,27-нд өгсөн. Тэгээд аудитаа хийлгээд 5,15 гэхэд аваачиж өгнө гэж байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Байхгүй гээд лавлаж асуухаар байхгүй гээд байх нь төвөгтэй байна. Өнгөрсөн хурлаар мэдэхгүй, чадахгүй гээд байсан. Би Эрдэнэбаяр захиралд гарын үсэг зуруулаад танилцаж гээд хүсэлт өгсөн. Одоо хүртэл хариу өгөөгүй. Эрдэнэбаяр захирал санаж байна уу?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- өгсөн.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Ингээд байхаар хэцүү байна. Яг нэг далдлаад, хууль бус юм хийгээд байгаа юм шиг. Нямжав та сая ярилаа. Үндэсний үйлдвэрээ дэмжээд гээд бид нар Засгийн газар, хөдөө аж ахуйн яам шиг хөтөлбөр хэрэгжүүлдэг агентлаг биш.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Үндэсний үйлдвэрээ дэмжихгүй төр байхад яагаад нэгэндээ дэмжлэг үзүүлж болдоггүй юм. Адилхан салбарын үйлдвэрүүд. Бид нар ч гэсэн ногдол ашиг авах хүсэлтэй байна. Их хэмжээний хувьцаа эзэмшиж байгаан хувьд. Тэгэхдээ харсаар байхад үндэсний үйлдвэр нь өчнөөн жил дэмжсэн байхад яагаад хариуд нь дэмжлэг үзүүлж болдоггүйн. 2003 оноос хойш та нар юугаар дэмжсэн юм. Ариг гал дэмжиж, хөрөнгийг нь бүтэн, газрыг хүнд алдчихгүй байсан. Хэрвээ газрын төлбөрөө төлөөгүй бол газраа алдчихсан, та нар хэрүүл хийх юмгүй байна. Үл хөдлөх хөрөнгө нь хураад уначихсан, бүх шугам хоолой нь зэврээд хэмхэрээд унасан байна. Тэрийг бүрэн бүтэн байлгахын тулд санхүүжилт өгөөд, үл хөдлөх хөрөнгийг нь хамгаалж, санхүүжилж байсан.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Буцаагаад зарж, авч болно шдээ.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Та нар ямар үүрэг гүйцэтгэсэн? Ариг галд ямар үүрэг гүйцэтгэсэн? Хувьцаа эзэмшигчийн хувьд өчнөөн жил хуралдаа суугаагүй. Тэр үед юу хийж байсан. Одоо л нэг хөрөнгө эргэлдүүлээд, хөрөнгийг үнэ цэнийг алдахаас өмнө эргэлтэнд оруульа гэсэн үед та нар гарч ирээд ноднингоос хойш асуудал үүсгээд, компанийг ингэж дарамтанд оруулаад байгаан?

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Юу эргэлдээд байгаан? Юу хийгдсэн? Монноос дээр юу хийсэн бэ?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Тэгээд газрын эрхийг нь цуцалсан, ямар ч юмгүй болсон байвал яахын? Тэгвэл жинхэнэ дампуурна биздээ. Хувьцаа чинь үнэгүй болно биздээ. Тэгвэл хувьцааны үнэ цэнийг алдуулахгүйн тулд хөрөнгийг өнөөдрийг хүртэл байлгаж байсан,

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

санхүүжүүлж байсан Ариггал яахаараа буруутаад байгаан? Хариуд нь зүгээр мөнгө байлгаж байхаар санхүүжилт өгсөн. Тэр мэдээж ТУЗ-ийн шийдвэр гарсан байгаа. ТУЗ-ийн гишүүдийн 100%-ийн саналын эрхтэйгээр асуудлаа шийдсэн бол заавал ХЭХурлаар оруулах шаардлага байхгүй. Мэдээлээд болно.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Адам байхгүй байгаад байгаа. Адам ер нь байдаг юмуу?

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Адам амьд юмуу, үхсэн юмуу?

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Адамын итгэмжлэлийг консулаар дамжуулаад авчихдаг юм гээд байхад бүтэн жил авч чадаагүй л байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Арай үхсэн хүнийг ингээд яваад байдаг юм биш биз?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Ярихад хэм хэмжээ гэж байдаг шүү.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Адамыг харъя.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Ямар юманд эрхзүйн үндэслэл гэж байх ёстой шүү.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Адамтай уулзмаар байна. ТУЗ-ийн даргаа хармаар байна.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Ийм том хэлцэл хийчихээд, гараад явдаг.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Ийм том хэлцэл хийчихээд бид нарыг хохироочихоод гараад явчихсан байна. Та бол компаниа дампууруулаагүй, хулгай хийгээгүй гээд байна.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Тийм. Хулгай хийгээгүй, худлаа яриагүй. Жил болгон ХЭХурал дээр энэ компани тайлангаа тавиад явж байсан. Тэр олон жил хаана нь байсан? Хувьцаа эзэмшигчид хуралдаа ирэхгүй яасан бэ?

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хаана байсан гэж юу гэсэн үг вэ? Би байнга ирж байсан.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Чамайг би эдний хурал дээр хараагүй.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Ажил хийх ёстой хүмүүс бол ТУЗ байдаг шүү.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- ТУЗ-ийн гишүүдээ өөрсдөө сонгочихож байгаа биз дээ.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Хуулиараа та нар санхүүгийн жил дуусснаас хойш 60 хоног дотор нэрээ дэвшүүлээд, ТУЗ-д ороод, хяналтаа хийгээд явахыг хэн ч хориглоогүй. Өнөөдөр та нар тийм үүргээ биелүүлээгүй, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлээгүй өдий хүрсэн. Тэр буруугаа өдий хүртэл үйл ажиллагаа явуулсан Гүйцэтгэх удирдлага, компанийн зарим хувьцаа эзэмшигчид рүү дайрч болохгүй.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Буруу байлгүй яахын. Хангалттай хөрөнгө оруулсан байгаа биз дээ. Та нар компанийг бүтэн хэмжээнд авчирлаа гээд байгаа ийм хэмжээний өр ширэнд оруулаад, ийм хэмжээнд хүргэснийг хангалттай юмуу?

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Та 4,6га газраа 35,2тэрбум.₮-өөр зарсныг хангалтай гэж үзэж байна уу?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Зөвшөөрч байгаа. Тухайн үед судалгаа хийгээд зарсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- 1м2 газар ямар үнэтэй байгаа вэ?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Мэдэхгүй. Ариг гал дээр та нар ямар газрыг тэгж яриад байгаан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Та мэдэхгүй юмаа, зөвшөөрч байгаа гээд байна?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Энэ дээр бол үл хөдлөх хөрөнгөө зарсан юм чинь газар нь дагаад шилжинэ. Угаасаа Иргэний хуульд байгаа, газраас салгавал хөрөнгө нь үнэ цэнээ алдах хөрөнгийг үл хөдлөх хөрөнгө гэнэ гээд байгаа. Тэгээд газаргүй хөрөнгийг үл хөдлөх хөрөнгө биш. Газаргүй хөрөнгийг хүн авахгүй.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Нямжав эгчээ, Хоосон газрыг 5 тэрбум төгрөгөөр зарчихаад байхад хоолтой ийм үл хөдлөх хөрөнгөтэй газрыг ийм хямдхан зарчихваа гээд хариу асуугаад байна. Та бол хангалттай гээд байна.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- 35 тэрбум төгрөгөөр зарсан. Ялгаагүй биздээ. 1м2 хуваахаар заримын хувьд.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Ялгаатай тийм том хэмжээний газрыг, маш их ялгаатай.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Нямжав бол хувьцаа эзэмшигч болохоор хамаагүй шдээ.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Төлөөлж байгаа учраас яан ийн хамаагүй.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Хувьцаа эзэмшигч болохоор ТУЗ-ийнхаа шийдвэрийг, компанийхаа бусад нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийнхээ шийдвэрийг дэмжиж байгаа. Нэгэнт гаргасан шийдвэрээ хамгаалаад дуусна хувьцаа эзэмшигчийн хувьд.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Буруу ч гэсэн хамгаалах уу?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Нэгийг харж нөгөө руу урвадаг хүн биш лдээ.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хууль бус байсан ч хамгаалаад дуусна гэж байгаа юмуу.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Мэдээж хуулийн үндэстэй байж таарна. Юу гэж хууль зөрчиж шийдвэр гаргаж дээ. Ер нь бол хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг адилхан шдээ.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Би нэг хэлчихье. Таны хэлсэн үгнээс ер нь халхавчилсан гэрээ гэдгийг маш гоё тайлбарлаж өглөө. Газрыг нь зарахаар үнэтэй болчихоод байдаг, тэгэхээр үл хөдлөх хөрөнгийг нь зарчихья, дагаад газрыг нь шилжүүлэх ёстой юм байна. Тэгэхээр бид нар халхавчилж, хямдхан зарснаар хүмүүст харуулж болох юм байна гэж та аягүй гоё тайлбарлаж өглөө.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Чи тэгж ойлгож байгаа бол чиний ойлголт.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Би тэгж ойлголоо. Би ер нь мэдээд авлаа. Ийм юм болдог юм байна гэдгийг ойлголоо.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Яаж ч мушгиж гуйвуулж болно л доо. Гэхдээ хүн хуулиа барьж, хуулиар хамаг юмыг шийдэх байлгүй.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Гэрээгээ харъя лдаа. Гэрээ байгаа шдээ.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Ер нь шударгаар хэлэхэд хүмүүст ойлгомжтойгоор юмаа тайлбарлачихсан, таниулсан, бичиг цаасан дээр буусан юмаа үзүүлчихвэл амар байна. Тэрэнтэй бол санал нэг байна.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Тэгвэл аль аль талдаа амар байна. Хардлага төрөхөөр байна. Юм асуухаар мэдэхгүй, цаасаар үзье гэхээр үзүүлэхгүй.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Юм мэдэхгүй болохоор юу ярихын бэ?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/-Цаасан дээр буусан юмыг харахгүй болохоор хардах сэрдэхийг буруутгах аргагүй л дээ.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Түрүү жил бас л ийм л болсон. Харъя гээд харуулаагүй.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Юм асуухаар мэдэхгүй, цаасын үзье гэхээр харуулахгүй. Ингэхээр чинь хэцүү байна. Одоо яваад ирэх юм уу? Өнгөрсөн жил бид та хэдийн итгэмжлэлийг иртэл 10 цаг хүртэл хүлээсэн шдээ. Одоо яваад аваад ирэх үү.

Энхцэцэг /Ня-бо/- Манай хөрөнгө худалдах комиссын нарийн бичиг Бэрээмэд дээр гэрээ байгаа. Би шаардлагатай үед хувилж авчихаад, СЗХороо зэрэгт хувилж авчихаад, буцаагаад өгчихдөг.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Одоо дуудаад авчих л даа.

Энхцэцэг /Ня-бо/- Бэрээмэд өчигдөр авыгаа аваад хөдөө явчихсан, байхгүй байна.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Дандаа шалтгаантай юм ярина. Ийм хүмүүс компани авч яваад, ийм байдалд аваачаад тавьж байгаа байхгүй юу. Сая Нямжав хэлээд байсан, хангалттай өрөнд оруулсан байна. Тийм биздээ. Эрдэнэбаяр захиралаа, хийсэн юм байхгүй, сүүлдээ зараад дуусгасан. Бид нар зарахаас өмнө танд хэлсэн. За ийм байна, тал нь ч болохнээ үлдэх юм байна гээд өнгөрсөн жил бид хэд тайвшраад гарсан.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Хойд газраа 35тэрбум төгрөгөөр зарах гэж байгаа, урд хэсэг нь үлдэнээ гээд та өөрөө хэлсэн.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Газар дээрээ юу хийх вэ гэж ярилцаж байсан.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Та байсан биздээ. Та сонсож байсан тээ Мөнхбат гуай.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Эцсийн тохиролцоонд бүгд зарагдсан. Та нартай хурал хийж байх үед зарим хэсгийг нь зарна гээд ХЭХурлын тогтоол гарч байсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Тэр чинь 2021 оны 8-р сард ХЭХурлын тогтоол гарсан. Дахиад 2022 онд бүгдээрээ ярьсан. Тэр дээр талыг нь зарна гэж байсан.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-Тийм. Зарим хэсгийг гэж байсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Зарим хэсгийн гэснийг би 2022 оны 4-р сарын ХЭХурал дээр асуусан. Яг аль хэсгийг вэ гэхэд Та хойд хэсэг үйлдвэр болон оффисын хэсэг гэж хэлсэн.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-2022 оны сүүлээр эцэслэн тохиролцсон.Эцэслэн тохиролцоходоо үл хөдлөх хөрөнгө дагалдаад газрын эрх нь шилжүүлж байна.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/-Тэгээд яагаад үнийн дүн нэмэгддэггүй юм бэ? Үнийн дүн нэмэгдэж, ядаж 2 дахин нэмэгдэх ёстой шдээ.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/-Тэгвэл бид нарт тэр газраас авах боломж байсан шдээ.

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Та нар журмын дагуу, хуулийн дагуу санал гомдлоо гаргаж болно. Угаасаа та нар шүүх цагдаа, АТГ өгөөд байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Дахиад өгнө. Харин аягүй сайн аргалдаг юм байна лээ.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хороог аргалсан байна лээ,

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Санал гомдол гаргах нь та нарын эрхийн асуудал.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Гаргана, гаргана. Илтэд доромжилж байгаа байхгүй юу. Өнөөдөр энд ирэхэд юу ч байхгүй. Ямар ч цаас гаргаад үзүүлэхгүй. Аваад ирээчээ гэхэд аавыгаа аваад хөдөө явсан. Хурал болгон дээр ингэж яриад байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Татварт хүртэл гаргаж өгөхгүй байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Татварын еранхий газар шалгалт хийнэ гэхээр юмаа гаргаж өгөхгүй. Өнгөрсөн жил танд компанийн материал гаргаж өг гээд хүсэлт гаргасан. Одоо өгөлдөө, яагаад өгөхгүй байгаан. Хувийн хэрэгтэй танилцмаар байна. Тунгалаг эгч рүү ярьсан. Та нар миний бичгийн хариу яах гэж байна гээд ярьсан одоо хүртэл хариу байхгүй. Ингэхээр чинь ямар хэрэг байгаа юм бэ? Биднийг хуурч байна шдээ. Адилхан хувьцаа эзэмшигчид шдээ. Ариг галд, надад 6%-ийн зээл өгөлдөө. Би авмаар байна. Тэгэх Нямжав эгчээ.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Бидэнд 6%-ийн зээл өгөх боломжтой юу?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Би эдний өмнөөс хариуот өгөх албагүй.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Та түрүүн өмнөөс нь хариулаад байсан биздээ?

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Би хувьцаа эзэмшигчийн хувьд анх гаргасан шийдвэрээ хамгаалж ярьсан.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Надад зээл өгөх үү.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Хөрөнгө зарах ХЭХурлын шийдвэрт манайх санал өгсөн. Тийм учраас шийдвэртээ үнэнч, тэрийгээ хамгаалж тайлбар хийсэн. Тэрнээс биш Гүйцэтгэх удирдлагын өмнөөс хариулт өгөөгүй.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Мөнхбат дарга, би 6%-ийн хүүтэй, барьцаагүй зээл авч болох уу.

Марал импекс/Хувьцаа эзэмшигч/- Болохгүй.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Болохгүй гэж байна. Тэгвэл Ариггал яагаад болж байгаан.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- 2003 оноос хойш Монноосны газар, үл хөдлөх хөрөнгийн татвар төлөхөд зээл өгсөн, бид зөрүүлээд ноолуурт дэмжлэг өгч болно.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Өрөө өгчихсөн шдээ.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Алдагдалтайгаар өгсөн шүү.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- 2017 оноос Чингис хаан банкнаас дандаа барьцаанд тавьж зээл аваад Кашмер холдинг. Кашмер Холдингт мөнгийг зээлдүүлээд өгчихсөн, одоо өмнөөс нь хүүгийн төлчихсөн. Кашмер Холдинг хэдэн хувийн хүүтэй төлөхийн? Тэр зээлийг нь хүртэл хаагаад өгч байгаа биздээ. Монноос хангалттай харж үзэж байна, өрөө төлж байна, хүүгийн нь төлж байна. Арай ч 5,7 тэрбум.₮-ийн татвар хураамж төлөхгүй. Эрдэнэбаяр захиралаа.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Хурлын дэгийн дагуу хүн болгоны 3 минут гэсэн, та хэдийн 3 минут өнгөрсөн байгаа. Гомдол санал байдаг бол холбогдох хуулийн дагуу санал гомдлоо бидэн рүү өгч болно. Та бүхний ярьсан асуудал бүгд энд протоколд тусгагдаж байгаа. Угаасаа холбогдох газруудад шалгагдаад явж байгаа. Одоо Хурлын цаг дуусч байна.

Ганболд /Хувьцаа эзэмшигч/- Нягтлангаас юм асууж болох уу. Би юм асуугаагүй байгаа. Дансны авлага 22 тэрбум. төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлага гэдэг нь аваагүй байгаа гэсэн үг штээ. Энэ дээр түрүүний ярианаас сонсоход газраа зараад шилжүүлсэн юм шиг байна. Бусад орлого гээд 35тэрбум төгрөг ороод ирсэн үү.

Энхцэцэг /Ня-бо/- 35 тэрбум.₮ орж ирээгүй байгаа. Яагаад гэвэл эрх шилжүүлэх татвараа төлөхийн тулд Татварт үл хөдлөхийн татварын 2%, эрхийн шимтгэлийн 10%-ийг төлөхөд 35 тэрбумаараа тайлагнадаг юм байна лээ. Ирээдүйд орж ирэх орлого гэж тайлан дээр бичсэн. Тэгээд орж ирсэн мөнгөнөөс 35 тэрбумаар авлага үүсгэхчээр зөрүү мөнгө нь авлага дээр очно. Шунхлай группээс 15 тэрбумын авлагатай, 11,5 тэрбум нь Ариг галаас, 5,6 тэрбум нь хуучин байсан авлага байгаа юм. Энэ 3 газраас авлагатай байгаа. 35 тэрбумаар татварын тайланг гаргах ёстой байсныг гаргаад, урьдчилж орж ирэх орлого гэж гаргасан.

Ганболд /Хувьцаа эзэмшигч/- Нягтлан бодох бүртгэлийн стандартаар ингэж орж ирээгүй орлогыг бусад орлого гэж болдог юм уу.

“МОННООС”

ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Энхцэцэг /Ня-бо/- Татварын тайлангаар яагаад гэвэл эрх шилжихэд 616сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн татвар төлсөн. Тэднийх суутган төлөлт хийгээд, манайх яг дансаар шилжүүлээгүй, манайд өгөх мөнгөнөөс тэднийх суутгаад төлсөн. Тэгэхээр тэр тайлагнахаар татварын тайлан маань яалтгүй үнийн дүн 35,2 тэрбум, газрын эрх шилжүүлэх 4,3 тэрбум, 10% гээд 35,2тэрбум төгрөгөөр тайлагнахаас өөр замгүй юм байна лээ. Тэгэхээр баланс дээр 35,2тэрбумаар орлогоо тусгасан.

Аргай бест /Хувьцаа эзэмшигч/- Стандартаараа тийм байна уу?

Энхцэцэг /Ня-бо/- Стандартаараа ч тэгж байгаа, татварын тайлангаараа ч ямар үнээр борлуулсан бэ гээд үл хөдлөх хөрөнгийн борлуулах үнээ бичиж байж, 2%-ийн татвараа төлдөг. 10%-ийн эрхийн шимтгэлийг шилжүүлэх үнийн дүн 4,3 тэрбумаа бичиж байж, энэ 2-ын нийлбэрээр татварын тайлан гараад байгаа. Тэгэхээр 35,2тэрбум.₮- өө бүтэн үнээр нь тусгасан байгаа.

Ганболд /Хувьцаа эзэмшигч/- Үндсэн хөрөнгө 2тэрбум байж байгаад хасчихсан юм байна тээ. Зарсан уу.

Энхцэцэг /Ня-бо/- Үлдэгдэл өртгөөрөө хассан.

Ганболд /Хувьцаа эзэмшигч/- Тайлан дээрээс би асууж байна. Өнгөрсөн жил 2тэрбум байсан байна. Би анх удаа хуралд сууж байгаагүй. Тайланг харахаар 2тэрбум.₮-ийн үндсэн хөрөнгө хасагдсан байна. Хасагдсан нь авч байгаа тал руу шилжсэн юмуу?

Энхцэцэг /Ня-бо/- Тэгсэн. Үл хөдлөх хөрөнгийн эрх нь шилжсэн болохоор хассан.

Ганболд /Хувьцаа эзэмшигч/- Шилжсэн мөртлөө нөгөө газар дутуу мөнгөө өгөөгүй байгаа юмуу? Хэзээ авах уу?

Энхцэцэг /Ня-бо/- График нь 2 жилийн хугацаатай хийгдсэн. 2024 оны 2 сард уусахаар байгаа. 2022 оны 7 сараас хойш графиз тохирсон байгаа. Тэгэхдээ үнэ дээр одоо ажиллаж байгаа комисс яриад үнэ нэмэх асуудлыг яриад явж байгаа юм байна лээ. Би бол тэрийг нь сайн мэдэхгүй. Тийм чиглэл хэлсэн. Тэгээд гэрээ эцэслэж болохгүй байна гээд зурагдахгүй байна гэсэн. Ямар ч байсан 35,2тэрбумаар урьдчилсан хэлцэл хийгдсэн учраас энүүгээрээ тайландаа тусгаад явж бай гэсэн.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Гэхдээ газар нь шилжсэн, барилга нь шилжсэн юман дээр дахиж гэрээ өөрчлөгдөнө гэж байхгүй. Үнийн дүн дээрээ эцсийн байдлаар тохирсон байлгүй дээ.

Энхцэцэг /Ня-бо/- Тохироогүй байгаа гэсэн. Яагаад гэхээр тэд эдээр зарсан гэсэн гомдол үүссэн болоод манайх үнэ дээрээ өөрчлөлт оруулах санал манай комиссоос санал тавьсан. Яг эцэслэж зурагдаагүй байгаа гэж би ойлгосон. Энэ ондоо 35,2тэрбум төгрөгөөр тайландаа тусгаад, үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх гээд 7,8-р сард татварыг нь төлөөд явсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Ер нь үл хөдлөх хөрөнгөө зараад, нахцал нь яаж авахаар тохирсон вч бэ?

Энхцэцэг /Ня-бо/- Урьдчилгаа 20% бэлнээр өгөөд, 10,10% төлж явна гэсэн.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хэдий хугацаатай вэ?

Энхцэцэг /Ня-бо/- График нь 24 сарын хугацаатай. Улирал тутам төлж байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Улиралд хэдийг авч байна.

Энхцэцэг /Ня-бо/- Улиралд 2,4 тэрбумыг авч байгаа. Урьдчилаад 4,8тэрбумыг авсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Улирал бүр 2,4тэрбум авч байгаагаа банканд ч юмуу, урт хугацаатай хөрөнгө оруулалт хийгээд явбал яадгийн. Одоо мөнгөн хөрөнгийн удирдлага тал руу явах ёстой байгаа. Зүгээр л найран дундаа яваад баймааргүй байна.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- 7,01 гэхэд ТУЗ-өөс өгсөн үүргийн дагуу Монноос ХК-ийг хойшид ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулахаа эцэслэн батлуулах юм. Бид үүнийг мэргэжлийн чиглэлийн хүмүүст судалгаа хийлгэж эхэлсэн байгаа. 7,1 гэхэд Монноос хойшид ингэж явна гээд эцэслэн шийдвэрлэгдэх байх.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Мэргэжлийн чиглэлийн гэж ямар хүмүүс байгаа вэ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Салбарын инженер техникийн ажилчид, маркетингийн менежерүүд гээд байгаа.

Алтансүх /Хувьцаа эзэмшигч/- Ноос угаах уу?

Энхцэцэг /Ня-бо/- Бас өөр шинэ бизнесийн чиглэлээр. Сая 2022 оны тайланг хэлэлцэх ТУЗ-ийн хурлаар дээр ороход бол ганцхан ноос угаах чиглэлээр яваад, орон нутаг гээд бүтэхгүй юм бишүү. Тийм болохоор чиглэлээ өөрчлөөд шинэ бизнес рүү орох юм байна уу гээд. Шинэ бизнесийн төсөл

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

хэрэгжүүлээч гэсэн үүрэг даалгавар Гүйцэтгэх удирдлагад өгсөн. Тэнд Эрдэнэбаяр захирал Гүйцэтгэх захирлын ажлаа биеийн байдлаас болоод болье гэсэн хүсэлтээ тавьсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Эрдэнэбаяр захирлаас асуухад 2022 оныг дүгнээд хэлэхэд та Монноос компанийн төлөө маш сайн ажилласан гэж үзэж байна уу?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Би өөрийгөө дүгнэвэл утгагүй байх. Та хэд дүгнэх байлгүй. Би өөрөө үзэхдээ бол ямар ч байсан хөрөнгийг нь устгаж үгүй болгоогүй хадгалж байсан гэдгээрээ гайгүй ажилласан гэж хэлнэ. Үйл ажиллагаа явуулах гэдэг дээр бол угаасаа тийм ч бололцоо байхгүй байсан.

Ганболд /Хувьцаа эзэмшигч/- Тодруулж болох уу? 35 тэрбум.₮-өөр зарсан байна. Үнийн дүн ч дүүрч, гэрээ хийсэн юм чинь. Түрүүний яриан дээр АПУ, Шунхлай зарсан гэдгийг ярьж байна. Энэ 2т хэд дээр зарсан юм бэ? Хэлж болох уу? Яаж хуваагдсныг хэлээд өгөөч.

Энхцэцэг /Ня-бо/- Шунхлай 24,7 тэрбум, АПУ-10,5 тэрбум.₮ байсан.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Гэрээг яаж ч хийж болно.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Өнгөрсөн жилийн хүсэлтээ мэдээлэл авья гэсэн.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- За би албан ёсоор хариуг нь ойрын үед өгүүлье.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Та яг хугацааг хэлээд өгөөрэй. Өнгөрсөн жил за гаргаж өгнө гээд байхгүй байна.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Та ажлаа хэзээ хүлээлгэж өгөх гэж байгаан? Та өргөдлөө өгсөн юм уу?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- ТУЗ-ийн хурлын шийдвэр гарвал хүлээлгэж өгнө. Халагдах саналаа өгсөн, цаасар өгөөгүй байна.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/- Таныг цаашид ийм байдалтай ажиллуулах үнэхээр хэцүү.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Энхцэцэг нягтлан та 2 талд ажиллаад байхаар ажил ихтэй бишүү.

Энхцэцэг /Ня-бо/- Ажил ихтэй байдаг болохоор би бас хүсэлтэй өгсөн байгаа. Би 2022 оноос эхлээд өгсөн. Оронд нь нягтлан олдохгүй байгаа учраас тавигдаагүй. Ирсэн ня-бо нь өндөр цалин нэхээд байна. Тэгэхээр Гүйцэтгэх захирал бид 2 ТУЗ-өөр шийдүүлвэ гээд хүсэлтээ өгсөн байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Та гүйцэтгэх захиралд өгөөд шийдүүлнэ шдээ. Тэрнээс өмнө саяны тэр дурдсан мэдээллүүдийг авмаар байна. Тэрэн дээр хүсэлтийг минь хангаж, шийдэж өгнө үү. Жилийн өмнө хүсэлтээ өгсөн. Яг жилийн дараа дахиад гуйж байна. Эрдэнэбаяр захирлаа, танилцмаар байна.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- ойлголоо.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Одоо компанид хөрөнгө юу үлдэвээ? Үл хөдлөх хөрөнгө, газар хувьцаа юу байна?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Нисэхийн газар байгаа. Үл хөдлөх хөрөнгө байхгүй.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/- Тоног төхөөрөмж байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хэдэн төгрөгний тоног төхөөрөмж үлдсэн бэ? Зүгээр төмөрийн хогонд өгөх гэж байна уу?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Угаах, хатаах 2 шугам байгаа. Кашмер Холдингийн агуулахад хадгалж байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Зарвал хэдэн төгрөг болох вэ? Зарвал үнэ хүрэхээр юмуу, төмрийн хогонд өгөхөөр юмуу?

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Та өнгөрсөн жил хог байна гэсэн.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Зарим нь хог болсон байсан. Бидний сэргээсэн 2 шугам бол байгаа. 2019, 2020-нд 1 шугамыг бүтэн сэргээсэн. Тэгээд үйл ажиллагаа эхлүүлэх гэж байхад инженерийн шугам сүлжээ болохгүй, бохирын шугам болохгүй байна гээд хориглосон. Тэгээд тэр ноолуур үйл ажиллагаа, ноосны үйл ажиллагаа явуулахыг хориглоод хаясан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Тэр тэгээд хэдэн төгрөгөөр үнэлэгдэх тоног төхөөрөмж байна.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/- Тэд эд гэж үнэлж чадахгүй.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/- Баланс дээр ямар үнэлгээтэй байгаа вэ?

Энхцэцэг /Ня-бо/- Баланс дээр 144 сая төгрөгний байгаад, үлдэгдэл өртөг нь 84сая төгрөгний үлдэгдэл өртөгтэй байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Нисэхийн газар тэр 2 байна. Өөр юу байна.

Пүрэвжав /Хувьцаа эзэмшигч/- Нисэхийн газар хэдий хэмжээний газар вэ?

"МОННООС"
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Энхцэцэг /Ня-бо/-8300м2 газар байгаа. Аж ахуйн зориулалттай газар.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/- Хойшоо оршуулгын наана байдаг газар. Өөр юм байна уу?

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/-Урьдчилж төлсөн зардал гэж баймаар юм. Энэ байх ёстой. Хаачив.

Энхцэцэг /Ня-бо/- Урьдчилж төлсөн зардал байгаа.

Алтансүх /хувьцаа эзэмшигч/-Тэр юу вэ?

Энхцэцэг /Ня-бо/-Тэр чинь төлөх зардал тооцоонуудаа. Шандас импекст гэхэд хүүгийн нь өгөөгүй байгаа.Ерөөсөө зардал оруулж яваагүй. Урьдчилж төлсөн зардал биш хуримтлагдсан татварын өглөг гэсэн дансанд тусгах ёстой юм билээ. Энгийг Аудитаас бас асуучихсан.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-Шандас импекс хэдэн хувийн хүүтэй билээ?

Энхцэцэг /Ня-бо/-Шандас импексийг бага, сарын 0,5%-ийн хүүтэй. Шандас импексийн өглөг намайг авахад байсан өглөг.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/-Урьдчилж төлсөн зардлыг хамгийн энгийнээр тайлбарлая. Манайх барилгын салбар. Барилга барьж байхад гарч байгаа зардлаа тусгадаг. Харин та татвар ч юмуу өөр юм тусгасан байна.

Энхцэцэг /Ня-бо/-Угаах шугамыг засвар хийж байхад хуримтлагдсан зардлууд байгаа. Тэрийг зардалд тусгаагүй, өртөг дээрээ нэмнээ гээд аваад үлдсэн байгаа. 200сая төгрөг байгаа.

Жигүүр /Хувьцаа эзэмшигч/-Нийт 4,4тэрбум.₮ байна шдээ. Зүгээр 5,10 сая юм яриагүй.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-Одоо өөр хөрөнгө байхгүй юу? Баянзүрхийн Гацууртын газар яасан бэ, 2500м2 газар байх ёстой.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-Тэр газрыг Нийслэлийн газрын алба хүчингүй болгуулсан. Ашиглахгүй байна гээд.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-Хэзээ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-2-3 жилийн өмнө.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-Өөр юу байна? Дорнод ноосны хувьцаа 20% байгаа юу?

Дорнод ноос ХК үйл ажиллагаа явуулаад байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-Гацууртын газар хураалгасан гэж үзэх үү, аль эсвэл зарсан уу.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-Нийслэлийн газрын албанд хураалгасан. Үйл ажиллагаа явуулахгүй байна гээд хураалгасан.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/-2 жил дараалан ашиглаагүй бол хураачихдаг.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-Захирамж нь байгаа юу? Ямар зориулалттай газар вэ?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-Аж ахуйн зориулалттай газар.

Шандас импекс /Хувьцаа эзэмшигч/-Дотор нь ядахдаа контейнер тавьчихгүй, хашаалчихгүй.

Тунгалаг /ТУЗ-ийн нарийн бичиг/-Дорнод ноосны 20%-ийн хувьцаа эзэмшдэг хэвээрээ байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-Дорнод ноос дээр юу хийхийн? Нисэхийн газар дээр юу хийхийн?

Алтансүх /хувьцаа эзэмшигч/-Манай охин компани шдээ.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-Төсөл байхгүй байна.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-Зарвал хэдэн төгрөг болох бол?

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-Тэр газрыг зарахгүй гэж үзэж байгаа. Дээр нь юу барих вэ гээд судалгаа явагдаж байгаа. Техникийн зах барих уу, зүгээр зах барих уу, цэцэрлэг барих уу гээд янз бүрийн санал яригдаж байгаа.

Мягмарсүрэн /Хувьцаа эзэмшигч/-Улаанбаатар хивстэй залгаа агуулахын зориулалттай газар байгаа.

Эрдэнэбаяр /Гүйцэтгэх захирал/-Хурлын дэгийн дагуу санал, асуултаа өндөрлөө. Та нарт өөр санал байвал холбогдох хууль журмын дагуу бичгээр өгч болно.

Одоо санал хураалтын ажилдаа оръё.

6.Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, саналын дүнг гаргаж

Тооллогын комиссын дарга Л.Пүрэвхүү Хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Л.Пүрэвхүү /ТКДарга/**-** Хуралд 11 саналын 223307 саналын эрхтэй оролцогч санал өгснөөс 9 саналын хуудас бүхий 222352 саналын эрх хүчинтэй, 2 саналын хуудас бүхий 955 саналын эрх хүчингүй тоологдсон.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Тооллогын дүнгээр: Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 174762 санал буюу 78,3%-ийн саналаар Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг, 174762 санал буюу 78,3%-ийн саналаар Компанийн 2023 оны удирдлагын зардлын төсвийг 3280000 төгрөгөөр батлах санал тооллогдов.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 174555 кумулятив санал буюу 78,2%-ийн саналаар Билл Холдсвортыг, 174555 кумулятив санал буюу 78,2%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, 174762 кумулятив санал буюу 78,3%-ийн саналаар Д.Мөнхбатыг, 174555 кумулятив санал буюу 78,2%-ийн саналаар С.Алимааг, 174555 кумулятив санал буюу 78,2%-ийн саналаар Ц.Цэнгэлбаярыг, 174555 санал буюу кумулятив 78,2%-ийн саналаар П.Оюунбаярыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр, 174555 кумулятив санал буюу 78,2%-ийн саналаар Б.Мэдрээг, 174555 кумулятив санал буюу 78,2%-ийн саналаар И.Сэр-Одыг, 174555 кумулятив санал 78,2%-ийн саналаар Л.Бүрэлтэгшийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгохыг тус тус тооллогдов.

ХЭХурлаас гарсан шийдвэр:

1. Монноос ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлав.
2. ТУЗ-ийн энгийн гишүүнээр кумулятив саналаар Билл Холдсворт, С.Мөнхжаргал, С.Алимаа, Д.Мөнхбат, Ц.Цэнгэлбаяр, П.Оюунбаяр нарыг тус тус сонгосныг батлав.
ТУЗ-ийн хараат гишүүнээр кумулятив саналаар Л.Бүрэлтэгш, И.Сэр-Од, Б.Мэдрээ нарыг тус тус сонгосныг батлав.
3. Компанийн 2023 оны удирдлагын зардлын төсвийг 3,280,000 төгрөгөөр батлав.

Тэмдэглэл бичсэн: Хурлын нарийн бичгийн дарга

Зөвшөөрсөн: Хурлын дарга

Х. 21



М.Тунгалаг

Х.Эрдэнбаяр